

**ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА  
2024 оны 05 дугаар сарын 01-ний өдөр, Лхагва гараг**

*Хуралдааны тэмдэглэлийн агуулга*

<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	1-7
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	8-48

---

<i>1.Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд нарын 3 гишүүн 2024.04.05-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/</i>	8-9
<i>2.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд нарын 3 гишүүн 2024.04.05-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/</i>	9-10
<i>3. Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд нарын 3 гишүүн 2024.04.05-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/</i>	10-11
<i>4.Байнгын хорооны тогтоолын төсөл /Чиглэл өгөх тухай/</i>	11-12
<i>5.Байнгын хорооны тогтоолын төсөл /Чиглэл өгөх тухай/</i>	12-34
<i>6.Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газарт чиглэл өгөх тухай/</i>	34-37
<i>7.Улс төрийн намын тухай хуулийн хэрэгжилтийн талаарх холбогдох байгууллагуудын мэдээлэл сонсох</i>	37-48

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы  
Төрийн байгуулалтын байнгын хорооны  
05 дугаар сарын 01-ний өдөр /Лхагва гараг/-ийн  
хуралдааны товч тэмдэглэл**

Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Н.Энхболд ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 52.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 12 цаг 27 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: А.Адъяасүрэн, Ж.Батсуурь, С.Бямбацогт, Г.Ганболд,  
Ц.Мөнх-Оргил, Ж.Эрдэнэбат;  
Чөлөөтэй: Ё.Баатарбилэг, Л.Оюун-Эрдэнэ.

**Нэг.Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд нарын 3 гишүүн 2024.04.05-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын дарга Б.Болдбаатар, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох, мөн хэлтсийн референт А.Наранцэцэг, Эрх зүйн дүн шинжилгээний хэлтсийн ахлах зөвлөх Ж.Сайнхишиг, мөн хэлтсийн Редакц, кодификацийн албаны ахлах зөвлөх Б.Батчимэг нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Байнгын хорооны дарга Н.Энхболд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3-г заасны дагуу санал хураалгах горимын санал гаргав.

**Н.Энхболд:** Байнгын хорооны дарга Н.Энхболдын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 2  
Бүгд: 10

Гуравны хоёроор дахин санал хураалгах санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Д.Сарангэрэлийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул санал хураалтын дүнг дэмжсэнээр протоколд тэмдэглүүлэх санал гаргав.

Нийт 10 гишүүнээс 9 гишүүн дэмжиж, гуравны хоёроор дахин санал хураалгах санал дэмжигдлээ.

*Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3-т нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр санал хурааж дэмжигдсэн боловч уг саналаар Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь дахин санал хураалгах шаардлагатай гэж үзсэний дагуу санал хураалт явуулав.*

**Н.Энхболд:** 1.Төслийн 9 дүгээр зүйлийн 9.18 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 1  
Бүгд: 10  
90.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 12 цаг 34 минутад хэлэлцэж дуусав.*

*Хоёр.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд нарын 3 гишүүн 2024.04.05-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/*

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын дарга Б.Болдбаатар, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Анар-Эрдэнэ, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох, мөн хэлтсийн референт А.Наранцэцэг, Эрх зүйн дүн шинжилгээний хэлтсийн ахлах зөвлөх Ж.Сайнхишиг, мөн хэлтсийн Редакц, кодификацийн албаны ахлах зөвлөх Б.Батчимэг нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Сарангэрэл үг хэлэв.

Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 12 цаг 37 минутад хэлэлцэж дуусав.*

***Гурав.Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд нарын 3 гишүүн 2024.04.05-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын дарга Б.Болдбаатар, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Б.Баярмаа, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох, мөн хэлтсийн референт А.Наранцэцэг, Эрх зүйн дүн шинжилгээний хэлтсийн ахлах зөвлөх Ж.Сайнхишиг, мөн хэлтсийн Редакц, кодификацийн албаны ахлах зөвлөх Б.Батчимэг нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 12 цаг 39 минутад хэлэлцэж дуусав.*

***Дөрөв. Байнгын хорооны тогтоолын төсөл /Чиглэл өгөх тухай/***

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох, мөн хэлтсийн референт А.Наранцэцэг, Эрх зүйн дүн шинжилгээний хэлтсийн ахлах зөвлөх Ж.Сайнхишиг нар байлцав.

Байнгын хорооны дарга Н.Энхболд тогтоолын төслийн талаар танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**Н.Энхболд:** “Чиглэл өгөх тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явууля.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 4

Бүгд: 11

63.6 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

*Уг асуудлыг 12 цаг 43 минутад хэлэлцэж дуусав*

***Тав.Байнгын хорооны тогтоолын төсөл /Чиглэл өгөх тухай/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхий аудиторын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Загджав, Үндэсний аудитын газрын Аудитын нэгдсэн удирдлага, зохицуулалтын газрын захирал, тэргүүлэх аудитор Я.Самбууням, мөн газрын аудитор Б.Мөнхтуяа, аудитын удирдлагын менежер Л.Мөнхцацрал, Санхүү-Нийцлийн аудитын газрын ахлах аудитор Ц.Батсүх, Чанарын баталгаажуулалтын газрын ахлах аудитор Б.Өлзий, Гүйцэтгэл-Нийцлийн аудитын газрын аудитор Б.Мөнхбадрал, Монголын Үндэсний олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн дарга Н.Монсор, мөн телевизийн Хяналтын зөвлөлийн дарга Д.Оюун-Эрдэнэ, Ерөнхий захирал Г.Гэрэл нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ц.Баянмөнх, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох, мөн хэлтсийн референт А.Наранцэцэг нар байлцав.

Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороогоор Үндэсний аудитын газраас 2024 онд “Монголын Үндэсний олон нийтийн радио, телевизийн 2021-2023 оны үйл ажиллагааны үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг Монгол Улсын Ерөнхий аудиторын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Загджав, ажлын хэсгийн танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг нар танилцуулав.

Тайлан болон ажлын хэсгийн танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатар, Д.Сарангэрэл нарын тавьсан асуултад Үндэсний аудитын газрын Аудитын нэгдсэн удирдлага, зохицуулалтын газрын захирал, тэргүүлэх аудитор Я.Самбууням, ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг, Үндэсний олон нийтийн радио, телевизийн Хяналтын зөвлөлийн дарга Д.Оюун-Эрдэнэ нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатар, М.Оюунчимэг, Д.Сарангэрэл нар үг хэлэв.

Байнгын хорооны дарга Н.Энхболд тогтоолын төслийн талаар танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд, Д.Сарангэрэл, Ж.Сүхбаатар нар үг хэлэв.

**Н.Энхболд:** “Чиглэл өгөх тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 5  
Татгалзсан: 6  
Бүгд: 11  
45.5 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэгийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Н.Энхболд:** Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэгийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 5  
Бүгд: 11  
54.5 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**Н.Энхболд:** “Чиглэл өгөх тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалтыг дахин явуулья.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 5  
Бүгд: 11  
54.5 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

*Уг асуудлыг 13 цаг 59 минутад хэлэлцэж дуусав.*

***Зургаа. Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газарт чиглэл өгөх тухай/***

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ц.Баянмөнх, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох, мөн хэлтсийн референт А.Наранцэцэг нар байлцав.

Байнгын хорооны дарга Н.Энхболд тогтоолын төслийн талаар танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатарын тавьсан асуултад Байнгын хорооны дарга Н.Энхболд хариулж, тайлбар хийв.

**Н.Энхболд:** “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанд оруулж батлуулах нь зүйтэй гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 5  
Бүгд: 11  
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул санал хураалтын дүнг дэмжсэнээр протоколд тэмдэглүүлэх санал гаргав.

Нийт 11 гишүүнээс 7 гишүүн дэмжиж, 63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 14 цаг 08 минутад хэлэлцэж дуусав.*

***Долоо.Улс төрийн намын тухай хуулийн хэрэгжилтийн талаарх холбогдох байгууллагуудын мэдээлэл сонсох***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Сонгуулийн ерөнхий хорооны дарга П.Дэлгэрнаран, мөн хорооны Тамгын газрын дарга Д.Бат-Эрдэнэ, мөн хорооны гишүүн бөгөөд Улс төрийн намын мэдээлэл арга зүйн газрын дарга Д.Баяндүүрэн, Монгол Улсын Ерөнхий аудиторын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Загджав, Үндэсний аудитын газрын Аудитын нэгдсэн удирдлага, зохицуулалтын газрын захирал, тэргүүлэх аудитор Я.Самбууням, Улсын дээд шүүхийн Тамгын газрын дарга С.Заяадэлгэр, мөн газрын Улс төрийн намын бүртгэлийн албаны дарга А.Батсүх, Сангийн яамны Нягтлан бодох бүртгэлийн бодлогын газрын дарга Б.Болормаа, Үндэсний статистикийн хорооны Нийгмийн статистикийн газрын дарга М.Оюунцэцэг, Жендерийн үндэсний хорооны нарийн бичгийн дарга бөгөөд ажлын албаны дарга Т.Энхбаяр, мөн хорооны Нийгмийн түншлэл, хамтын ажиллагааг хариуцсан мэргэжилтэн Д.Чанцал нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох, мөн хэлтсийн референт А.Наранцэцэг нар байлцав.

Улс төрийн намын тухай хуулийн хэрэгжилтийн талаарх мэдээллийг Сонгуулийн ерөнхий хорооны дарга П.Дэлгэрнаран, Улсын дээд шүүхийн Тамгын газрын дарга С.Заяадэлгэр, Үндэсний аудитын газрын Аудитын нэгдсэн удирдлага, зохицуулалтын газрын захирал, тэргүүлэх аудитор Я.Самбууням, Сангийн яамны Нягтлан бодох бүртгэлийн бодлогын газрын дарга Б.Болормаа, Жендерийн үндэсний хорооны нарийн бичгийн дарга бөгөөд ажлын албаны дарга Т.Энхбаяр, Үндэсний статистикийн хорооны Нийгмийн статистикийн газрын дарга М.Оюунцэцэг нар танилцуулав.

Мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг, Н.Энхболд нарын тавьсан асуултад Үндэсний аудитын газрын Аудитын нэгдсэн удирдлага, зохицуулалтын газрын захирал, тэргүүлэх аудитор Я.Самбууням, Жендерийн үндэсний хорооны нарийн бичгийн дарга бөгөөд ажлын албаны дарга Т.Энхбаяр, Улсын дээд шүүхийн Тамгын газрын дарга С.Заяадэлгэр нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүд Улс төрийн намын тухай хуулийн хэрэгжилтийн талаарх Сонгуулийн ерөнхий хорооны дарга П.Дэлгэрнаран, Улсын дээд шүүхийн Тамгын газрын дарга С.Заяадэлгэр, Үндэсний аудитын газрын Аудитын нэгдсэн удирдлага, зохицуулалтын газрын захирал, тэргүүлэх аудитор Я.Самбууням, Сангийн яамны Нягтлан

бодох бүртгэлийн бодлогын газрын дарга Б.Болормаа, Жендерийн үндэсний хорооны нарийн бичгийн дарга бөгөөд ажлын албаны дарга Т.Энхбаяр, Үндэсний статистикийн хорооны Нийгмийн статистикийн газрын дарга М.Оюунцэцэг нарын мэдээллийг сонсов.

*Уг асуудлыг 14 цаг 46 минутад хэлэлцэж дуусав.*

Байнгын хорооны хуралдаанаар 7 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 2 цаг 19 минут үргэлжилж, ирвэл зохих 19 гишүүнээс 11 гишүүн хүрэлцэн ирж, 57.9 хувийн ирцтэйгээр 14 цаг 46 минутад өндөрлөв.*

Тэмдэглэлтэй танилцсан:  
ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН  
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Н.ЭНХБОЛД

Тэмдэглэл хөтөлсөн:  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ  
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР



## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 05 дугаар сарын 01-ний өдөр,  
Лхагва гараг  
Төрийн ордон “Жанжисин Д.Сүхбаатар”  
танхим  
12 цаг 27 минут.

### ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

**Н.Энхболд:** Төрийн байгуулалтын  
байнгын хорооны гишүүдийн олонх  
хүрэлцэн ирлээ.

Мөнхцэцэг гишүүн, Амарсайхан  
гишүүн, Доржханд гишүүн, Оюунчимэг  
гишүүн, Тогтохсүрэн гишүүн, Жаргалмаа  
гишүүн, Энхболд гишүүн, Занданшатар  
гишүүн, Сарангэрэл гишүүн ирээд ирц  
бүрдсэн учраас Төрийн байгуулалтын  
байнгын хорооны 24 оны 5 сарын 1-ний  
өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.  
Хэлэлцэх асуудлаа танилцуулъя.

Нэгдүгээрт, Монгол Улсын Их  
Хурлын чуулганы хуралдааны дэгийн  
тухай хуулийн шинэчилсэн найруулгын  
төсөл, хамт өргөн мэдүүлсэн хуулийн  
төслүүд, эцсийн хэлэлцүүлэг хийнэ.

Хоёрдугаарт, Монгол Улсын Их  
Хурлын тухай хуулийн шинэчилсэн  
найруулгын төсөл, хамт өргөн мэдүүлсэн  
хууль, тогтоолын төслүүд, эцсийн  
хэлэлцүүлэг хийнэ.

Гуравд, Монгол Улсын Их Хурлын  
хяналт шалгалтын тухай хуулийн  
шинэчилсэн найруулгын төсөл, хамт  
өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд, эцсийн  
хэлэлцүүлэг хийнэ.

Дөрөвдүгээрт, “Чиглэл өгөх  
тухай” Байнгын хорооны тогтоолын  
төсөл.

Тавдугаарт, “Чиглэл өгөх тухай”  
Байнгын хорооны тогтоолын төсөл.

Зургаад, Улс төрийн намын тухай  
хуулийн хэрэгжилтийн талаар холбогдох  
байгууллагуудын мэдээлэл сонсоно.

Долоодугаарт, Бусад гэж асуудал  
байгаа. Хэлэлцүүлгийн явцад энэ тэр  
материал ороод ирвэл нэг асуудал  
байгаа. Ингээд хэлэлцэнэ.

Хэлэлцэх асуудалтай  
холбогдолтой саналтай гишүүн байна  
уу?

Байхгүй байхгүй байна.  
Асуудалдаа оръё.

**Монгол Улсын Их Хурлын  
чуулганы хуралдааны дэгийн тухай  
хуулийн эцсийн хэлэлцүүлгийг хийнэ.**

Эцсийн хувилбарын төсөл, эцсийн  
хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай  
танилцуулгыг тараасан байгаа.  
Тогтохсүрэн ажлын хэсгийн гишүүн  
Тогтохсүрэн гишүүн товч  
танилцуулчихъя. Тогтохсүрэн гишүүний  
микрофоныг өгье.

**Д.Тогтохсүрэн:** Баярлалаа.

Байнгын хорооны дарга, эрхэм  
гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн  
Нямаагийн Энхболд, Мөнхбаатар,  
Тэмүүлэн нараас 24 оны 4 сарын 5-ны  
өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн  
Улсын Их Хурлын хуралдааны дэгийн  
тухай хуулийн шинэчилсэн найруулгын  
төсөл болон хамт өргөн мэдүүлсэн  
хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг  
Улсын Их Хурал 24 оны 4 дүгээр сарын  
25-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар  
хэлэлцэж, эцсийн хэлэлцүүлэгт  
бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын  
байнгын хороонд шилжүүлсэн.

Төрийн байгуулалтын байнгын  
хороо 24 оны 5 дугаар сарын 1-ний

өдрийн өнөөдрийн хуралдаанаараа энэ Дэгийн тухай хуулийн эцсийн хэлэлцүүлгээ явуулах гэж байна.

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр санал хурааж дэмжигдсэн боловч уг саналаар Байнгын хороонд оролцсон гишүүд бас санал гаргах нь зүйтэй гэж ингэж үзсэн. Тийм учраас 42.2-т заасны дагуу 1 санал хураалт явуулахаар энэ дээр бэлтгэсэн байж байгаа.

Та бүгдийг Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн эцсийн хэлэлцүүлгийг дэмжиж, шийдвэрлэж өгөхийг хүсье.

Баярлалаа.

**Н.Энхболд:** Баярлалаа. Тогтохсүрэн гишүүний. Ажлын хэсэг танилцуулчихъя. Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Үнэнбат, Хуулийн хэлтсийн дарга Болдбаатар, Тэр хэн сууж байна? Агар-Эрдэнэ нар Төрийн байгуулалтын байнгын хорооны асуудал харууцсан. Чуулганы хуралдаан дээр хэлэлцээд 1 саналыг дахиж ярих тухай чиглэл өгсөн. Ажлын хэсгээс санал боловсруулаад оруулсан байгаа. Энэ нь төслийн 9 дүгээр зүйлийн 9.18 дахь хэсгийг хасах тухай санал.

Энэ бол хэлэлцсэн Дэгийн хуулийн 42.2-оор холбогдох Байнгын хороо эцсийн хэлэлцүүлэг явуулахдаа дараах тохиолдолд санал хураалт явуулж болно.

42.2.3-д нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр санал хурааж дэмжигдсэн боловч уг саналаар Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн гурваны хоёроос доошгүй нь дахин санал хураалгах шаардлагатай гэж үзсэн бол асуудлыг дахиж хэлэлцэх ёстой.

Тэгэхээр сая танилцуулгаас та нар сонссон 1 зарчмын зөрүүтэй санал байгаа гэж. Энийг гуравны хоёроос доошгүй нь дэмжвэл дахиад санал хурааж явуулна. Тэгэхээр энэ 42.3-ын

дагуу дахин санал хураалт явуулъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Саналаа Сүхээ гишүүнээ. Сүхээ гишүүн саналаа.

10 гишүүнээс 8 дэмжиж 80 хувийн саналаар дэмжигдлээ.

Сарангэрэл гишүүнийг дэмжсэнээр аваарай 9 гишүүн дэмжсэн байна. 90 хувийн саналаар.

Горимын санал дэмжигдсэн учраас зарчмын зөрүүтэй саналаараа санал хураана.

Төслийн 9 дүгээр зүйлийн 9.18 дахь хэсгийг хасах. Ажлын хэсгийн санал. Санал хураалт явуулъя. Дэмжье гэсэн санал хураалт санал хураалт.

10 гишүүн оролцож, 9 гишүүн дэмжиж, 90 хувийн саналаар дэмжигдэж байна.

Үүгээр Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоолын төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Байнгын хорооны танилцуулгыг нэгдсэн хуралдаанд Тогтохсүрэн гишүүн танилцуулна.

Баярлалаа дараагийн асуудалдаа оръё. Сарангэрэл гишүүнд микрофон өгөөдөх. Их Хурлын хууль дээр үү?

Чуулганы дэгийн тухай хуулийн эцсийн хэлэлцүүлгийг явуулж дууслаа. Дараагийн асуудалдаа оръё.

12.34 цаг

**Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоолын төслүүд.**

Байнгын хороогоор анхны хэлэлцүүлгийг явуулсан, чуулганаар. Одоо

Байнгын хорооны ажлын хэсгийн танилцуулгыг Тогтохсүрэн гишүүн. Тогтохсүрэн гишүүн эцсийн хэлэлцүүлэгт бэлдсэн тухай танилцуулга.

**Д.Тогтохсүрэн:** Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн төслийг анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын нэгдсэн чуулганаар хийгээд эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байнгын хороонд шилжүүлсэн.

Ажлын хэсэг хуралдаад эцсийн хэлэлцүүлэг дээр Улсын Их Хурлын тухай хууль дээр Цэцийн зөрүүтэй санал байхгүй. Тийм учраас эцсийн хэлэлцүүлгийг явуулж өгөхийг хүсье. Баярлалаа

**Н.Энхболд:** Танилцуулгатай холбоод асуух гишүүн байна уу? Сараа яах юм энэ чинь? Дараагийн энэ хууль дээр, энэ шүү дээ одоо Их Хурлын хууль дээр. Асуулт алга байна. Саналтай гишүүн байна уу? Сарангэрэл гишүүний микрофоныг өгье.

**Д.Сарангэрэл:** Баярлалаа дарга. Баярлалаа. Улсын Их Хурлын тухай хуулийн 27.3.4 дээр Хүний эрхийн дэд хороо гэж байгаа юм. Тэгээд энэ дээр Хүний эрх, жендерийн гэдэг ерөөсөө ганц үг нэмээд Жендерийн дэд хороо, Хүний эрх, жендерийн дэд хороо гэдэг л ийм саналыг бид нар гаргаж байгаа юм. Тийм, Хүний эрх, жендерийн дэд хороо.

Учир нь ер нь Олон улсын парламентын хүний эрхийн асуудлаар бидэнд бас энэ энэ чиглэлээр зөвлөмж өгсөн. Нөгөө талаас Монгол Улсын парламент өөрийн үнэлгээгээ хийсэн бас анхны парламент болчихоод байгаа юм. Ингээд олон улсын зөвлөхүүд жендерийн бүтцийн асуудал Монгол Улсын парламентад байхгүй байна. Тийм учраас бүтэц дотроо тодорхой хэмжээгээр оруулаарай гэдэг ийм зөвлөмжийг өгсөн

юм. Тэгээд энэ зөвлөмжтэй холбоотойгоор Дэд хороо шинээр нэмж байгуулах тухай санал биш, Хүний эрхийн дэд хороон дээр Хүний эрх, жендерийн хороо гэдэг ийм л санал байгаад байгаа юм. Энэ саналыг хүлээж авна уу гэж хүсэж байна.

**Н.Энхболд:** Нэгдүгээрт, бид нар анхны хэлэлцүүлгээ хийчихсэн. Чуулганы нэгдсэн хуралдаанаар энэ асуудал хэлэлцэгдчихсэн. Тэр үед энэ асуудал хөндөгдөөгүй учраас яг одоо Дэгийн хууль зөрчиж тэрийг оруулж болохгүй байна.

Хоёрдугаарт, энэ хуулийн маань 27.4-д энэ хуулийн 27.3-д зааснаас бусад Дэд хороо байгуулах, татан буулгах, тэдгээрийн дагнан харуцах асуудлыг тогтоох асуудлыг харьяалах Байнгын хорооны саналыг үндэслээд нэгдсэн хуралдаанаар шийдвэрлэж болно гэсэн ийм нээлттэй заалт байж байгаа. Тэгэхээр энэ заалтыг ашиглаад хууль батлагдсаны дараа Их Хурал өөрөө Байнгын хороо хуралдаж байгаад ийм Дэд хороо гэсэн Дэд хороо байгуулах боломж нь бол хуулиараа нээлттэй байгаа гэдгийг хэлчихье.

Гишүүд санал хэлж дууслаа. Үүгээр Улсын Их Хурлын тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явж дууслаа. Баярлалаа. Дараагийн асуудалдаа орьё. Тогтохсүрэн гишүүн танилцуулчихъя чуулган дээр.

12.37 цаг

**Одоо Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч Тогтохсүрэн танилцуулна.**

**Д.Тогтохсүрэн:** Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн Энхболд, Мөнхбаатар, Тэмүүлэн нараас

24 оны 4 сарын 5-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Улсын Их Хурал 24 оны 4 сарын 25-ны өдөр анхны хэлэлцүүлэг хийгээд Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлсэн.

Энэ төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэхээр ажлын хэсэг хуралдаад эцсийн хэлэлцүүлэг дээр зарчмын зөрүүтэй санал байхгүй учраас эцсийн хэлэлцүүлгийг хийх нь зүйтэй гэж үзсэн.

Тийм учраас Байнгын хорооны гишүүд та бүгдийг дэмжихийг хүсье. Баярлалаа.

**Н.Энхболд:** Ажлын хэсгийн ахлагчийн танилцуулгатай холбогдуулж асуулттай гишүүн байна уу?

Алга байна.

Саналтай гишүүн байна уу?

Байхгүй байна.

Үүгээр Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг Байнгын хороогоор явуулж дууслаа.

Танилцуулгыг нэгдсэн хуралдаанд Тогтохсүрэн гишүүн тавина. Дараагийн асуудалдаа оръё.

12.39 цаг

**Байнгын хорооны тогтоолын төсөл байгаа. Чиглэл өгөх тухай.**

Энэ Төрийн албаны зөвлөлийн ажлын тайлантай Байнгын хорооны хуралдаанаар үүний түрүүчийн удаа бид нар танилцсан. Үүнтэй холбогдуулаад Байнгын хорооноос тогтоол гаргахаар шийдсэн байгаа. Тогтоолын төслийг та

бүхэнд хүргэсэн. Би уншаад танилцуулчихъя.

Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол “Чиглэл өгөх тухай” Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.7, 23.2.14 дэх заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооноос тогтоох нь:

1.Төрийн албаны зөвлөлийн хууль тогтоомжоор хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлсэн талаар 2023 оны тайланг хэлэлцээд Төрийн албаны тухай хуулийн хэрэгжилтийг хангахтай холбогдуулан дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар Оюун-Эрдэнэ-д даалгасугай.

1.Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл олгох тухай, Төрийн албан хаагчид шагнал олгох тухай, Ажлын гүйцэтгэлийн үнэлгээ, улирлын ажлын үр дүнг үндэслэн мөнгөн урамшуулал олгох тухай, Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох тухай, Төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад 1 удаагийн буцалтгүй тусламж олгох тухай, Албан үүргээ гүйцэтгэх явцад төрийн албан хаагчийн амь нас хохирсон тохиолдолд ар гэрт нь 1 удаагийн буцалтгүй тусламж олгох тухай, Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэхэд цалин урамшуулал олгох тухай, Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм, төрийн албан хаагчийн улсын нэгдсэн тоо бүртгэлд хөтлөх, мэдээлэл авах тухай, Сургалтын агуулга, хөтөлбөр батлах тухай, Төрийн улс төрийн албан тушаалд ажилласан хугацааг төрийн захиргааны албан тушаалын зохих ангилалд ажилласан хугацаанд дүйцүүлэн тооцох тухай дүрэм, журмыг хууль тогтоомжид нийцүүлэн өөрчлөх.

2.Монгол Улсын Их Хурлын 2019 оны 1 дүгээр сарын 17-ны өдрийн Төрийн албаны зөвлөлийн ажлын албаны бүтэц

батлах, орон тооны дээд хязгаарыг тогтоох тухай 07 дугаар тогтоолын хэрэгжилтийг ханган сургалт, судалгаа, мэдээллийн нэгдсэн сангийн нэгжийн үйл ажиллагааны төсөв санхүүжилтийг шийдвэрлэх.

3.Төсвийн Засгийн газраас байгуулагдаж байгаагүй Зөвлөл, Комиссын ажлын албанд ажиллаж байгаа албан хаагчийн албан тушаалын цалин, зэрэглэлийг хууль тогтоомжид нийцүүлэн 2024 онд багтаан тогтоох.

2.Төрийн албаны зөвлөлийн хууль тогтоомжоор хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлсэн талаарх 2023 оны тайланг хэлэлцээд хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангахтай холбогдуулан дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Төрийн албаны зөвлөл Цэдэвсүрэнд даалгасугай.

1.Улсын Их Хурлын 2019 оны 2 дугаар сарын 1-ний өдрийн төрийн жинхэнэ албан хаагч болон төрийн албанд нэр дэвшигчийн эрх зөрчигдсөн тухай маргааныг хүлээн авч, хянан шийдвэрлэх журам батлах тухай 20 дугаар, 2019 оны 2 дугаар сарын 1-ний өдрийн төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох, журам батлах тухай 21 дүгээр тогтоолыг хуульд нийцүүлэн нэмэлт, өөрчлөлт оруулах тухай саналыг 2024 оны 6 дугаар сард багтаан Байнгын хороонд ирүүлэх.

2.Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Төрийн албаны зөвлөлийн хамтран болон Төрийн албаны зөвлөлийн бүрэн эрхийн хүрээнд баталсан бусад шаардлагатай дүрэм, журамд өөрчлөлт оруулах ажлыг 2024 онд багтаан зохион байгуулах.

3.Улсын Их Хурлын Тамгын газраас хууль тогтоомжоор хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлсэн талаарх Төрийн албаны зөвлөлийн 2023 оны тайланд хийсэн шинжилгээ, зөвлөмж, дүгнэлтийг хэрэгжүүлж, Төрийн албаны зөвлөлийн

2024 оны үйл ажиллагааны тайланд тусгаж ажиллах.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороо Энхболд-д даалгасугай гэсэн ийм тогтоолын төсөл байна.

Бид нар урьд нь тайлангаа сонсоод, нэлээн сайн ярилчихсан. Үүнийхээ дагуу Байнгын хорооноос ийм тогтоол гаргая гэж шийдвэрлэсэн байгаа.

Тогтоолын төсөлтэй холбогдуулаад асуух гишүүн байна уу?

Алга байна. Саналтай гишүүн байна уу?

Алга байна.

Тэгвэл Байнгын хорооны тогтоолыг баталъя гэсэн саналаар санал хураалт явуулъя. Санал хураалт. Пүүжээ.

11 гишүүнээс 7 оролцож, 63.6 хувиар тогтоол батлагдлаа. Баярлалаа. Дараагийн асуудалдаа оръё.

12.43цаг

**“Чиглэл өгөх тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл.**

Энэ Монголын Үндэсний олон нийтийн радио, телевизтэй холбоотой, Улсын үндэсний аудитын газраас гүйцэтгэлийн аудитын тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан тогтоол Байнгын хорооноос гаргах ёстой.

Гүйцэтгэлийн аудитын тайланг гишүүдэд тараасан. Та бүхнийг танилцсан гэж бодож байна. Тогтоолын төслийг би уншиж танилцуулна. Ажлын хэсгийн ажлын хэсгийг урья. Ажлын хэсгийн нэр хаа байна? Энд байна. Асуудлыг хэлэлцэхэд оролцох ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя.

Монгол Улсын Ерөнхий аудиторовын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Загджав, Аудитын нэгдсэн удирдлага, зохицуулалтын газрын захирал, тэргүүлэх аудитор Самбууням, мөн газрын Удирдлагын менежер Мөнхцацрал, Санхүү-Нийцлийн Аудитын газрын ахлах аудитор Батсүх? Тэр байна. Чанарын баталгаажуулалтын газрын ахлах аудитор Өлзий? Байна, байгаа. Аудитын нэгдсэн удирдлага зохицуулалтын газрын дарга Мөнхтуяа, Гүйцэтгэл-Нийцлийн аудитын газрын аудитор Мөнхбадрал, Үндэсний олон нийтийн радио, телевизээс Үндэсний зөвлөлийн дарга Монсор? Монсор дарга ирсэн байна. Хяналтын зөвлөлийн дарга Оюун-Эрдэнэ, Ерөнхий захирал Гэрэл, Гэрэл хаана байна? Гэрэл захирлыг дуудаадхаарай. Дарга нь ороод ирлээ. Монголын Үндэсний олон нийтийн радио, телевизийн дарга Гэрэл? Тэр.

Одоо тайланг Ерөнхий аудиторовын үүргийг түр орлон гүйцэтгэгч Загджав танилцуулна. 4 номерын микрофон өгье.

**Д.Загджав:** Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе.

Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын болон Төсвийн байнгын хороодын саналд үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэг, 6 дугаар зүйлийн 6.3.1, 6.3.3-д заасан бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2023 оны 152 дугаар тушаалаар баталсан Төрийн аудитын байгууллагын 24 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөөг баримтлан гүйцэтгэсэн аудитын талаар танилцуулъя.

Аудитын зорилго нь Монголын Үндэсний олон нийтийн радио, телевизийн 2021-2023 оны үйл ажиллагааны үр дүнд аудит хийж,

дүгнэлт, зөвлөмж боловсруулан Улсын Их Хурлын Байнгын хороо холбогдох байгууллагуудад танилцуулахад чиглэсэн.

Аудитыг дараах зорилтын хүрээнд гүйцэтгэлээ. Үүнд:

Монголын Үндэсний олон нийтийн радио, телевизийн үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжид нийцүүлж, үр дүнтэй хэрэгжүүлсэн эсэх.

2.Төсөв санхүү, хөрөнгө нөөцийг зохих ёсоор бүрдүүлж, үр ашигтай зарцуулсан эсэхэд нь үнэлэлт дүгнэлт өгөх. Аудитор Улсын Их Хуралд 1 асуудлыг толилуулж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт 1, Сангийн яам 1, Монголын Үндэсний олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөл 5, Хяналтын зөвлөл 1, Ерөнхий зөвлөл, Ерөнхий захиралд 7, нийт 16 зөвлөлд өгч, Үндэсний зөвлөлд зөрчил арилгуулах 1 албан шаардлага хүргүүлээ.

Аудитаар илэрсэн зарим алдаа, зөрчлийг танилцуулъя.

Монголын Үндэсний олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөл нь 2021-2023 оны хооронд хэлэлцвэл зохих зарим асуудлыг цаг тухайд нь шийдвэрлээгүйгээс байгууллагын санхүү, төсөв, хүний нөөцийн удирдлагын хүрээнд өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг доголдуулах эрсдэл үүсгэж, зарим тогтоол нь эрх зүйн маргаан дагуулж, засаглалын хувьд тогтворгүй байх нөхцөлийг бүрдүүлсэн байна.

Монголын Үндэсний олон нийтийн радио, телевизийн 2019-2023 оны стратегийн төлөвлөгөөний дэвшүүлсэн зорилго, зорилтын хэрэгжилт тодорхойгүй, үр дүнг тайлагнаагүйгээс үнэлж дүгнэх боломжгүй байна.

Хөтөлбөрийн бодлогыг үндсэн зорилтод нийцүүлэн тэнцвэртэй бэлтгээгүй, шинжлэх ухаан, хүүхэд, танин мэдэхүйн мэдэхүйн залууст зориулсан цэнгээнт нэвтрүүлгийн

эфирийн цагт эзлэх хувь бага, хөдөлмөрийн бодлогод хяналт тавих хэлбэр тодорхойгүй, хэрэгжилт хангалтгүй байна. Мөн сүүлийн 3 жилд зар сурталчилгааг хуульд заасан хувь хэмжээнээс хэтрүүлэн түгээсэн бөгөөд зар сурталчилгаа болон захиалгат нэвтрүүлгийн гүйцэтгэлд тавих дотоод хяналтын тогтолцоо бүрдээгүйгээс байгууллагад төвлөрөх орлогод сөргөөр нөлөөлж, алдаа зөрчил үүсэх нөхцөл бүрдүүлж байна.

Монголын Үндэсний олон нийтийн радио, телевизийн үйлчилгээний хөлсний үнийн шинэчлэлийг хийх талаар өмнөх аудитор өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, улсын төсвийн дэмжлэг буурсан зэргээс алдагдал өр төлбөрийн хэмжээ өссөн байна.

Телевизийн нэвтрүүлгийн үйлчилгээний хөлс захиалгат нэвтрүүлгийн тарифын шинэчлэл хийгдээгүй байхад эх үүсвэрийн дутагдлыг нөхөх зорилгоор өөрийн орлогыг жил бүр нэмэгдүүлэн төлөвлөж байгаа нь арилжааны телевизүүдтэй өрсөлдөөнд орох, орлого олох үйл ажиллагаанд хэт анхаарал хандуулах сул талыг үүсгэж, улмаар Олон нийтийн радио, телевизийн үнэт зүйл, хуулиар хүлээсэн үндсэн зарчим, нийтлэл, нэвтрүүлгийн бодлого алдагдах нөхцөлийг бүрдүүлж байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөв 2018 оноос хойш олгоогүйгээс барилга, байгууламж, инженерийн дэд бүтцийн засвар, ашиглалт, нөхөн сэлбэлт, шинэчлэлийн ажлууд цаг тухай бүр нь гүйцэтгэх боломжийг алдагдуулж, хэвийн үйл ажиллагаанд доголдол үүсэх нь эрсдэлийг бий болгож байна.

Монголын Үндэсний олон нийтийн радио, телевизийн газар, зам талбай, барилга байгууламжийн хүрэлцээ сайтай боловч зарим хөрөнгийн ашиглалтыг сайжруулах зөвшөөрөгдсөн түвшинд эдийн засгийн эргэлтэд оруулж,

элэгдлийн зардлыг нөхөх, байгууллагын алдагдлыг бууруулж, үр дүнг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллаагүй байна.

Мөн эд хөрөнгийн өмчлөлийн эрх, бүртгэл, тайлагналтай холбоотой материаллаг хэмжээний асуудлыг шийдвэрлээгүй, зарим тэвчиж болох зардлыг бууруулах арга хэмжээ аваагүй, худалдан авах ажиллагааны хэрэгжилт холбогдох хуульд бүрэн нийцэхгүй байна.

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг өглөө. Үүнд:

Засаглалд оролцож буй субъектуудийн ажлын уялдаа хангалтгүй, хамтарч ажиллах соёл тогтоогүй, манлайлын оновчтой хэв маягийг хэрэгжүүлээгүйгээс байгууллагын бүтээмж, үр дүнг дэмжсэн нэгдсэн удирдлага ханган ажиллах боломж алдагджээ.

Монголын Үндэсний олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн зарим гишүүдийг холбуулах хуульд заасан мэргэжлийн шаардлагад нийцүүлэн сонгон шалгаруулж томилоогүйгээс Үндэсний зөвлөлийн чиг үүргээ хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж чадахгүй байна.

3. Үндэсний зөвлөл нь хөтөлбөрийн бодлогод хэрэгжилт тавих, техник, технологийн сүлжээг хөгжүүлэх, техник хангамжийн бодлогыг тодорхойлох, санхүү, эдийн засгийн чадавхыг сайжруулах, бүтэц зохион байгуулалтыг оновчтой болгох зэрэг шийдэл хүлээсэн арга хэмжээнүүдийг тухай бүр нь хэлэлцэж шийдвэрлээгүйгээс байгууллагын үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж байна.

4. Хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлээгүй, зөрчсөн, хэрэгжих боломжгүй шийдвэр гаргасан хуралдааны идэвх оролцооноос үл хамаарч урамшууллыг тогтмол авах зэргээр холбогдох хууль болон журамд

заасан эрх, үүргээ зөрчсөн Үндэсний зөвлөлийн гишүүдэд хариуцлага тооцох эрх зүйн зохицуулалтгүй байна.

5. Үндэсний зөвлөлөөс телевизийн нэвтрүүлгийн үйлчилгээний хөлсний хэмжээг шинэчлэн улсын төсвөөс үзүүлэх санхүү, хөрөнгө оруулалтын дэмжлэгийг нэмэгдүүлэх санал хүсэлтийг Засгийн газарт удаа дараа уламжилсан боловч шийдвэрлээгүйгээс шалтгаалж зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр дутааж үйл ажиллагаа доголдох эрсдэл үүссэн байна.

6. Хяналт тавих нэгжүүдийн бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлоогүйгээс тэдгээрийн хэрэгжүүлсэн үйл ажиллагаа гаргасан шийдвэрийн хэрэгжилт хангалтгүй, үр дүнд хүрэхгүй байна.

7. Хяналтын зөвлөлөөс Үндэсний зөвлөлийн гишүүнийг эргүүлэн татах зөвлөмжийг сонгосон байгууллагад хүргүүлснийг шийдвэрлэж, харуу ирүүлээгүйгээс Үндэсний зөвлөлийн үйл ажиллагаанд тодорхойгүй байдал үүссэн байна.

8. Монголын Үндэсний олон нийтийн радио, телевизийн 2019-2023 оны стратегийн төлөвлөгөө болон жил бүрийн телевиз хөтөлбөрийн бодлогын хэрэгжилтийг тайлагнаагүйгээс шалтгаалж хүрсэн үр дүнг үнэлэх боломжгүй байна.

9. Гүйцэтгэх удирдлага бүтэц, орон тоог оновчтой зохион байгуулаагүй, удирдах түвшний албан хаагчдыг сонгон шалгаруулалтгүйгээр түр орлон гүйцэтгэгчээр томилсон ажилтнуудын ажлын гүйцэтгэл, цаг ашиглалтад тавих дотоод хяналтыг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

10. Үйл ажиллагааны алдагдалд өр төлбөр өссөн нь улсын төсвөөс үзүүлэх санхүүгийн дэмжлэгийн хэмжээ буурсан, өөрийн орлогыг нэмэгдүүлэх боломж хязгаарлахын тулд цалин хөлс болон

бусад зардлууд нэмэгдсэнээс шалтгаалжээ.

11. Санхүүгийн эх үүсвэрийн дутагдалтай байдал нь орлого олох үйл ажиллагаанд хэт анхаарал хандуулах, Олон нийтийн радио, телевизийн үндсэн зарчим, нийтлэл, нэвтрүүлгийн бодлого алдагдахад хүргэж байна.

12. Үл хөдлөх хөрөнгийг дахин үнэлж, стандарт, хууль, эрх зүйн шаардлагад нийцүүлж бүртгэж тайлагнах, хөрөнгийн ашиглалтыг сайжруулах, зөвшөөрөгдсөн түвшинд эдийн засгийн эргэлтэд оруулж, үр ашгийг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

13. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль болон холбогдох журамд нийцүүлэн худалдан авах ажиллагааг зохион байгуулаагүй. Шилэн дансны тухай хуульд заасны дагуу мэдээллийг хугацаанд бүрэн байршуулаагүй, төрийн аудитын байгууллагаас өмнөх аудитор өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

14. Орлогод тавих дотоод хяналт сул, хяналтын үр дүнтэй тогтолцоо бүрдээгүйгээс гэрээ байгуулалгүй реклам, зар сурталчилгаа, захиалгат нэвтрүүлгийн үйлчилгээ үзүүлэх зарим гэрээг дүгнэж тайлагнаагүй зэргээс орлогыг цаг тухайд нь бүрэн төвлөрүүлэх нөхцөлийг алдагдуулж байна.

15. Монголын Үндэсний олон нийтийн радио, телевизийн цахилгаан, дулаан, дулааны төвлөрсөн дэд бүтцийн системээс бусад байгууллагууд хэрэглээгээ хангаж байгаагаас ачаалал үүсгэж, ашиглалтын зардлыг хянаж, бууруулах боломжийг алдагдуулж байна.

Аудитаар илэрсэн асуудлыг шийдвэрлэхийн тулд дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэхийг зөвлөж байна.



Монгол Улсын Их Хуралд  
толилуулах нь:

Үндэсний зөвлөлийн гишүүдийг холбогдох хуульд нийцүүлж, нэр дэвшсэн салбарын чиглэлээр нь ажлын туршилага, мэргэжил болон мэргэжлийн шаардлагад нийцүүлж нээлттэй сонгон шалгаруулах эрх зүйн орчныг бүрдүүлэх.

Монгол Улсын Засгийн газрын  
Хэрэг эрхлэх газарт.

Олон нийтийн радио телевизийн тухай хуульд заасны дагуу телевизийн нэвтрүүлгийн үйлчилгээний хөлс, түүний хэмжээг шинэчлэн тогтоох, өмнөх аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэх.

Сангийн яаманд.

Монголын үндэсний олон нийтийн радио, телевизийн үйл ажиллагааг хэвийн явуулахад шаардагдах санхүүгийн дэмжлэгийг бодит нөхцөл байдалд тулгуурлан төсөвт тусган олгох, гүйцэтгэлд нь хяналт тавих.

Үндэсний зөвлөлд.

Хуульд заасан эрх зүйн хэм хэмжээ, зарчмыг дагаж мөрдөх. Хяналт болон удирдлагыг оновчтой хослуулж, байгууллагад үр дүнтэй хамтран ажиллах, эерэг соёл, манлайллын төлөвшүүлэх, хөтөлбөрийн бодлогод хяналт тавих. Радио, телевизийн техник, технологийн сүлжээг хөгжүүлэх, техник хангамжийн бодлогыг тодорхойлох чиг үүргээ хэрэгжүүлж ажиллах эрх зүйн зөрчилтэй тогтоол шийдвэр гаргахгүй байхыг, телевизийн нэвтрүүлгийн үйлчилгээний хөлсний хэмжээг шинэчлэн тогтоох талаар тооцоо, судалгааг үндэстэй боловсруулан Засгийн газарт санал хүргүүлж шийдвэрлэх, хяналт тавих чиг үүрэг бүхий бүтцийн нэгжүүдийн эрх зүйн байдлыг сайжруулж үр ашигтай ажиллах тогтолцоог бүрдүүлэх. Үндэсний зөвлөлийн албан хэрэг хөтлөлт, архивын үйл ажиллагааг хууль, дүрэм, журамд

нийцүүлж хэрэгжүүлэх, гаргасан шийдвэрийн ил тод байдлыг ханган ажиллах, Хяналтын зөвлөлд хөтөлбөрийн бодлогоос бусад асуудлаар гарсан Үндэсний зөвлөлийн шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавьж, хэрэгжилтийг нь хангахад дэмжлэг үзүүлэх.

Монголын Үндэсний олон нийтийн радио, телевизийн ерөнхий захиралд.

Монголын Үндэсний радио, телевизийн стратегийн төлөвлөгөөг шинэчлэн боловсруулан батлуулж хэрэгжилтийг нь тайлагнах. Хүний нөөцийн удирдлагын байгууллагын батлагдсан орон тоо, бүтцэд нийцүүлж хэрэгжүүлэх, удирдах түвшний албан хаагчдыг холбогдох журмын дагуу сонгон шалгаруулж томилох, ажлын цаг ашиглалт, бүртгэлд хяналт тавих, бодит гүйцэтгэлд үндэслэн цалин урамшууллын олгож байх, хөтөлбөрийн бодлогыг хараат бусаар хэрэгжүүлэх, дүн шинжилгээ хийх, хуульд заасан нэвтрүүлгийн чиглэлүүдийг тэнцвэртэй байхаар төлөвлөх, зар сурталчилгааг хуулиар тогтоосон хэмжээнээс нь хэтрүүлэхгүй байх, реклам зар сурталчилгаа, захиалгат нэвтрүүлгийг хэрэгжүүлэхтэй холбоотой дүрэм, журмыг боловсронгуй болгох, түүнд тавих дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлж сайжруулах, үл хөдлөх хөрөнгийн эрхийн эрсдэлийг хууль, эрх зүйн шаардлагад нийцүүлж авах, дахин үнэлгээ хийлгэж, стандартын дагуу бүртгэж, тайлагнах хөрөнгийн ашиглалтыг сайжруулж, үр ашгийг нь нэмэгдүүлэх, цахилгаан, дулааны төвлөрсөн дэд бүтцийн системийн ачаалал, ашиглалтын зардлыг хянаж, бууруулах талаар арга хэмжээ авч ажиллах, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль болон журамд нийцүүлэн худалдан авах ажиллагааг зохион байгуулах, Шилэн дансны тухай хуульд заасны дагуу мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулж, аудитор өгсөн зөвлөмжийг

төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж ажиллах.

*Анхаарал тавьсанд баярлалаа.*

Манай энэ Аудитын сэдэвт энэ ажлыг Аудитын нэгдсэн удирдлагын газрын захирал, тэргүүлэх аудитор Самбууням голлон төлөвлөгөө баталж, энэ дээр ажилласан байгаа. Тэгээд бид нар саяын хийсэн зүйлүүдтэй холбогдуулаад хариулахад бэлэн байна.

**Н.Энхболд:** Загджав даргад баярлалаа. Бид нар энэ шалгалтыг бол Төрийн байгуулалтын байнгын хорооноос албан ёсоор хүсэлт тавьж байж хийлгэсэн шалгалт байгаа юм. Удаа дараа асуудлууд гарсан ажил нь хуулийн дагуу явагдаж чадахгүй, ялангуяа гүйцэтгэх удирдлагын зүгээс дураараа загнасан зүйлүүд их гарсан. Тэрнээс болж энд дурдагдаж байгаа их хэмжээний алдагдал байгууллагын өмнө учирчихсан байгаа. Тэгээд Үндэсний зөвлөл гүйцэтгэх удирдлагын хооронд зөрчилдөөнтэй, хууль зөрчсөн үйлдлүүд гарч байсан. Дураараа загнаж байсан юмнууд их болж байсан учраас энэ шалгалтыг оруулсан зориуд.

22 онд Төрийн байгуулалтын байнгын хорооноос тогтоол гарч байсан. Мөнхбат даргыг ажиллаж байх үед 4 сарын 20-нд. Асуудлыг авч хэлэлцээд Үндэсний олон нийтийн радио, телевизэд чиглэл өгч байсан. Хэрэгжсэн зүйл үндсэндээ байхгүй. Тэрнээс хойш жил гаруй болсны дараа дахиад Байнгын хорооноос ажлын хэсэг гаргаж, Үндэсний зөвлөл, гүйцэтгэх удирдлагын ажлуудтай танилцсан. Энэ ажлын хэсгийг Оюунчимэг гишүүн ахалж ажилласан. Тэгэхээр Оюунчимэг гишүүн ажлынхаа дүнг бас хамт ярьчихъя. Тэгээд нэгмөсөн асуулт хариултдаа оръё. хэдүүлээ. Ажлын хэсгийг ахалсан Оюунчимэг гишүүнийг сонсьё.

**М.Оюунчимэг:** Баярлалаа. Үндэсний аудитын газрын гүйцэтгэлийн энэ тайланг бас харлаа. Уг нь манай

аудитынхан их мундаг чанартай хийдэг. Энэ удаад олон нийтийн радио, телевизийн засаглалд оролцож буй этгээдүүдийн ажлын уялдаагүй байдал, санхүүгийн эх үүсвэрийн дутагдлаас шалтгаалж байгууллагын хэвийн үйл ажиллагаа алдагдсан гээд санхүүгийн болоод засаглалын хямралд орсон энэ нөхцөл байдлыг их л зөөлнөөр дүгнэж хэлсэн байна. Ийм зүйлийг одоо Үндэсний олон нийтийн радио, телевиз цаашид давтагдах ёсгүй.

Яагаад гэвэл энэ чинь олон нийтийн радио, телевиз байгаа. Тэгээд манай Ажлын хэсэг Төрийн байгуулалтын байнгын хорооны 2024 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн 03 дугаар тогтоолоор Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлантай танилцаж, шаардлагатай бол хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан. Энэ ажлын хэсгийн ахлагчаар миний бие, ажлын хэсгийн бүрэлдэхүүнд Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр, Ж.Батсуурь, Г.Ганболд нар ажилласан.

Ажлын хэсэг Үндэсний олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөл, гүйцэтгэх удирдлага, албан хаагчдын төлөөлөл бүхий хүмүүстэй 1 дүгээр сарын 17-ны өдөр уулзалт зохион байгуулж мөн санал солилцсон. Ажлын хэсэг дээрх уулзалтын үеэр тавигдсан асуудлууд болон Байнгын хороонд ирүүлсэн өргөдөл, гомдлыг нягталж үзээд дараах дүгнэлтийг боловсруулж танилцуулж байна.

Төрийн байгуулалтын байнгын хорооноос байгуулагдаж байсан ажлын хэсгүүдийн тайлан, мэдээлэл Улсын Их Хурлын Тамгын газрын Хяналт шалгалт, үнэлгээний газраас Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлан, мөн санхүүгийн болон гүйцэтгэлийн аудитын тайлангуудад дурдагдсан хэд хэдэн асуудлууд дахин хөндөгдөж байна.

Нэгд. Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.5 дахь заалтад олон нийтийн радио телевизийн санхүүжилтэд улсын төсвөөс дэмжлэг үзүүлнэ гэж заасан боловч дэмжлэгийг олгохтой холбоотой харилцааг нарийвчлан зохицуулаагүй тул төсвийн дэмжлэг нь Сангийн сайдын багцаас олгодог тул төсвийн дэмжлэгийг авах хүндрэлтэй, жил бүр харилцан адилгүй олгогдох зэрэг бэрхшээл үүссэн байна.

Хоёрт, Хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсэгт олон нийтийн радио, телевизийн нэвтрүүлгийн үйлчилгээний хөлсний хэмжээг олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн саналыг үндэслэн Засгийн газар тогтооно гэж заасан. Засгийн газраас өнгөрсөн хугацаанд энэ хураамжийг нэмэгдүүлэх, байгууллагын саналыг хэлэлцээгүй. 2005 оны доллартой дүйцүүлсэн 1100 төгрөгийн хураамжаар тооцсон журам одоо хүртэл үйлчилж байгаа нь Монголын Үндэсний олон нийтийн радио, телевизийн санхүүгийн эх үүсвэр алдагдахад ороход хүргэж байна.

Засгийн газраас төсөв, инфляц, үнийн өсөлт зэргийг харгалзан үзэж шинээр хураамжийг тогтоох шаардлагатай байна.

Гуравт, Хяналтын зөвлөлийн хуулиар хүлээсэн чиг үүргийн хэрэгжилт хангалтгүй буюу олон нийтийн радио, телевизийн санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд тавих хяналт маш сул байна. Иймд Хяналтын зөвлөлд Үндэсний зөвлөлийн гишүүнийг сонгохыг хориглох болон Хяналтын зөвлөлийн гишүүнд тавигдах шаардлагыг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Дөрөвт, санхүүгийн үйл ажиллагаа доголдож, 2023 оны байдлаар 4 тэрбум 487.3 сая төгрөгийн өр нийгмийн даатгалын шимтгэлийн санд үүссэн. Энэ өмнөх оноос 2 дахин өссөн үзүүлэлттэй байгаа юм. Тус

байгууллагад үүсээд байгаа санхүүгийн хямралыг богино хугацаанд даван туулах төлөвлөгөө баталж ажиллах шаардлагатай байна.

Иймээс цаашид Олон нийтийн радио, телевизийн тухай хуульд шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүдийг хийж олон нийтийн эрх ашигт үйлчилж, тэдний өмнө хариуцлага хүлээн хяналт явуулдаг олон нийтийн радио, телевизийг бий болгож бэхжүүлэх, олон нийтийн радио, телевизийн нийт 750 ажилчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг сайжруулах цогц арга хэмжээ авч ажиллахад анхаарахыг сануулж байна. Баярлалаа.

**Н.Энхболд:** Баярлалаа Аудитын ерөнхий газрын тайлан, манай ажлын хэсгийн тайлантай холбогдуулаад ажлын тайлан, дүгнэлттэй холбогдуулаад асуух гишүүд байвал нэрээ өгье. Хоёулантай холбогдуулаад.

Сарангэрэл гишүүнээр тасаллаа. Сүхбаатар гишүүний микрофоныг өгье.

**Ж.Сүхбаатар:** Би яах гэсэн юм ингээд тайлан сонсоод л ажлын хэсгүүд гараад л би үзэгчийн хувиар л хэлмээр байгаа юм л даа. Одоо үзэгчид ингээд л харж байгаа. Манайх Их Хурлын ажлын хэсэг олон удаа ажилласан даа. Манай гишүүд ч гэсэн уулзаад л, яриад л тэгээд л дүгнэлт хийхээрээ ерөөсөө Үндэсний олон нийтийн телевиз дампуурлаа гэсэн. Одоо гүн хямралд орлоо гээд л ингээд л. Энэ телевиз манай, бидний төлөө үйлчлэхгүй байна гээд л ингээд л яриад л. Энэ чинь угаасаа Үндэсний олон нийтийн телевизийг бодлогынх нь хувьд аваад үзэх юм бол Монголын ард түмний эрх ашигт ашгийн төлөө хөөцөлдөхгүйгээрээ тэр хуульд нь заачихсан байж байгаа л даа бодлого нь. Тэгээд бодлого нь болохгүй байгаа юм бол байхгүй шүү дээ.

Тэгэхээр ерөөсөө хоёр л юм байгаа байхгүй юу. Захиргаа, санхүүгийн асуудал. Захиргаа, санхүү. Тэгээд бид нар засаглал говеринс /governance/ гэж яриад

байдаг л даа. Гүүд говеринс /good governance/ буюу үр ашигтай сайн засаглал гэж ярьдаг. Тэгэхээр энэ засаглал болохгүй байна гээд энэ тод яах вэ аудитын дүгнэлтийг гаргахад засаглал нь болохгүй байна л гэж байгаа юм. Тэгэхээр засаглал болохгүй байна гэдэг чинь юу юм бэ гэхээр хүн л гэсэн үг л дээ.

Тэгээд энэ Үндэсний зөвлөл болохгүй байна, гүйцэтгэх удирдлага болохгүй байна гэж. Тэгээд л манай энэ Их Хурал дээр бас асуудал байна л даа Энхболд дарга. Энэ Их Хурал тэр хүнээ томилохдоо Үндэсний зөвлөлдөө хүнээ зөв томилж болдоггүй юм уу? Хариуцлага шүү. Энэ чинь нэртэй, устай хүмүүс л тэр хүмүүсийг нэр дэвшүүлж л оруулж ирсэн Үндэсний зөвлөлд байгаа хүмүүс. Тэнгэрээс бууж ирээгүй. Ингээд л гайхацгаагаад л бие биеэсээ асуугаад л энэ чинь шараад л байгаа шүү дээ. Энэ Үндэсний зөвлөлд чинь дандаа нэртэй устай хүмүүсийг нэртэй тодорхой газруудаас нэр дэвшүүлээд л оруулаад ирчихсэн. Тэгээд л тэд нар нь бодлого явуулж байгаа. Тэдний чадамжгүй байдлын төлөө тэгээд хэн хариуцлага хүлээх юм? Аудит хүлээх юм уу? Одоогийн байгаа удирдлага хүлээх юм уу? Одоо эсвэл байгаа бид нар Их Хурлын гишүүд гэдгээрээ өөрсдөө хүлээх юм уу?

Тэгэхээр тэр Үндэсний зөвлөл өөрөө хэний өмнө хариуцлага хүлээх юм бэ гэдэг асуудал байхгүй юу. Тэрнээс тэр дотор, байгууллага дотор тэр булангийнх нь юмыг нь янзлаагүй байна, цалинг нь тэдэн сар олгоогүй байна, тэр нь дутагдалтай байна гээд ингээд байж болохгүй. Бодлого бол гарчихсан. Төрийн бодлого ийм телевизтэй байна аа, нийтийн, үндэсний, олон нийтийн дэлхий дахины ВВС, Японы NHK гээд шиг ийм загвараар жижиг Монгол Улс мэдээллийн орон зай, аюулгүй байдал, үндэснийхээ юмыг хамгаална гээд бодлого нь гарчихсан.

Тэр бодлого хэрэгжихгүй дампуурчихлаа, гүн хямралд орчихлоо гээд байдаг. Тэгээд хуулиа янзална гээд

байгаа юм. Тэгээд хуулиас болоод байгаа юм бол тэгвэл ямар хуулийн заалтууд байна? Оюунчимэг гишүүнээс хуулийн заалт нь жишээлбэл ямар заалтууд дутуу байгаад байгаа юм? Эсвэл хүнээсээ болоод байгаа юм бол тэр Үндэсний зөвлөлийг нь өөрчлөн байгуулах, татан буулгах арга хэмжээ авах ч шинэ засаглалын хэлбэрт орох ёстой. Энхболд дарга өмнө нь энэ хуулиуд дээр Тогтохсүрэн дарга эд нар энд олон жилийн өмнө оролцоод л ингээд л явж байсан.

Тэгээд яг Үндэсний олон нийтийн телевизийг би сэтгэл дотроо дотно боддог. Үзэгчийн хувьд бас үздэг бас. Үзэхгүй, үздэггүй гэж хэлэхгүй. Нэвтрүүлэг нь би дандаа бүгд сонирхолгүй гэж хэлэхгүй. Гэхдээ тийм хэвшмэл, тогтсон, уйтгартай гэдэг нэг тийм юм бол байгаа. Сүүлийн үед иргэдээ сонсьё, таны телевиз, бид бол таны телевиз шүү, бидний телевиз шүү гэдэг ойлголтыг, нийтийн телевиз шүү гэдэг ойлголтыг бол өгөх энэ бодлогоо явуулах гэж оролдож байгаа байх. Тэгээд энэ рүүгээ явах нь зөв.

Би энэ хэлж байгаа нь аудитын зөвлөмж л байгаа Их Хуралд толилуулж байна ингээд явж байна. Тэгээд л яг ингээд сонсохоор Оюунчимэг гишүүнээ ингээд харахаар энэ өөрөө төрийн оролцоотой байгаад байгаа байхгүй юу. Тэгээд энэ чинь төр гээд хэн гэхээр Их Хурал, Засгийн газрын холбогдох байгууллагууд нэрээ дэвшүүлж. Тэгээд чадахгүй байгаа бол одоо тэгээд энийг чинь яах юм? Тэрнээс энд байгаа хэдэн хүн чичлээд, мянга засаглалаа сайжруул гээд байдаг тэгээд энэ гүйцэтгэх удирдлага нь ч яаж сайжруулах юм бүү мэд. Үндэсний зөвлөл нь болохгүй бол би энд чуулган дуусаж байгаа ч гэсэн дараачийн шинэ Их Хурал энэ Үндэсний зөвлөлөө Үндэсний зөвлөл шиг л байгуулах хэрэгтэй байхгүй юу. Үндэсний зөвлөл нь нийтийнхээ өмнө тайлагнах, Монгол Улсын Их Хурлын өмнө тайлагнах хэрэгтэй байхгүй юу. Тэгээд тэр сонсгол хийгээд бид сурч байна шүү дээ. Сонсгол

хийх хэрэгтэй л дээ Үндэсний олон нийтийн хэмжээнд. Гэхдээ энэ телевизээ имижийг нь муутгах, алга болгох, доош нь хийх, гутаах байдлаар явж болохгүй. Энэ телевизийг хайрлаж, хамгаалж, босгож ирэх ёстой байхгүй юу.

**Н.Энхболд:** Оюунчимэг гишүүн.

**М.Оюунчимэг:** Сүхбаатар гишүүн яг хуульч хүний хувьд хамгийн чухал асуудлыг асуучихлаа л даа. Засаглал гэдэг дээр яг бид нарын алдаа байгаад байна гэдэг нь Үндэсний олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүдийн үүрэг, хариуцлага тэд яг юу хийх ёстой юм, ямар байдаг юм, хаанаас томилогдсон юм, яаж ажлаа тайлагнах ёстой юм гэдэг энэ бол завхарсан.

Анх Үндэсний зөвлөлийн гишүүд томилогдох үед тийм байгаагүй, маш хариуцлагатай байсан анхны. Сүүлийнх нь тэгээд л ер нь ерөнхий захирлаа унагаах, эсвэл ерөнхий захирлын талдаа орох юм уу, эсвэл тийм хувийн ашиг сонирхол нь дэндчихээд байна л даа. Тэгээд Үндэсний зөвлөл, Хяналтын зөвлөл гээд энэ байгууллагууд нь яг нөгөө Үндэсний олон нийтийн радио, телевизийн хуульд заасан дагуу ажиллахаа байчихсан. Одоо манай дээр гэхэд бие биедээ гомдол мэдүүлчихсэн, энийг огцруулаад өгөөч, энийг эргүүлээд татаад өгөөч гээд гарын үсэг зурчихсан юмнууд хэд хэдээрээ ирчихсэн.

Тэгэхээр бид нар энэ Олон нийтийн радио, телевизийн тухай хуульд өөрчлөлт оруулаад Үндэсний зөвлөлийн гишүүдийн ер нь тоог эсвэл цөөлөх зайлиггүй шаардлагатай гэж харж байгаа. Тоог цөөлөх, дээрээс нь эргүүлэн татдаг болох хуулийн заалт өгч улам хариуцлагажуулах. Ингэж засаглалын болоод санхүүгийн хямралд орохгүй байхыг Үндэсний зөвлөл, тэр Хяналтын зөвлөл нь тэндээ уг нь хийх үүрэг нь байгаа байхад хэрэгжүүлэхгүй байгаад байгаа. Тэгсэн хэр нь бид эргүүлэн татаж чаддаггүй. Тэгээд эргүүлэн татаач гэхихээр одоо яг хуулийн заалт

дээр тийм юм байхгүй байгаад байгаа гээд байгаа учгаас нэгд үүнийг бид зайлиггүй хуульд өөрчлөлт оруулж засах хэрэгтэй байгаа.

Хоёр дахь зүйл нь энэ улсын төсвөөс санхүүгийн дэмжлэг үзүүлдэг, энэ төсөв хэлэлцэх үед бид улсын төсөвт санхүүжилтийг нь суулгадаг хэр нь энэ одоо Сангийн сайдын багц руу орчихдог. Тэгээд эд нар Сангийн сайдаасаа очоод л яг Сангийн яамны салбар байгууллага шиг санхүүжилтээ нэхээд л. Тэр нь 1 удаа бага, эсвэл их ч юм уу ийм хачин юм руу орчихсон.

Гурав дахь зүйл нь бүүр 2005 онд Сарангэрэл дарга би энэ тэр ажиллаж байх үед маань Билигт дарга байх үед энэ хураамжийг 1 доллартой тэнцүүлж баталсан хураамж өнөөдөр хүртэл огт өөрчлөгдөөгүй явж байгаа. Тэгээд энэ бүх байдал нь энэ байгууллагыг тэр ерөнхий захирал нь ч өөрөө яг тэр мэргэжлийн нээлттэй сонсголоор, шударгаар томилогддоггүй. Янз бүрийн ингээд улс төрийн шалтгаантай юм уу, эсвэл бүлэглэлийн шалтгаантай ч юм уу мэдэхгүй янз бүрийн ингээд томилогдчихдог. Тэгээд энэ нь эргээд ажиллаж чадахгүй, хүлээн зөвшөөрөгдөж чаддаггүй, янз янзын алдаа зөрчил гаргаад байдаг. Тэр хүндээ Үндэсний зөвлөл нь хариуцлага тооцож чаддаггүй хүртэл байж байна л даа.

Тэгэхээр иймэрхүү зүйлийг бид Олон нийтийн радио, телевизийн тухай хуулиар зарим зүйлийг нь өөрчлөлт оруулж хариуцлагажуулах ёстой гэж бодож байгаа. Тэгээд Ганболд гишүүн бас бид нар нийлээд энэ Олон нийтийн радио, телевизийн тухай хуульд өөрчлөлт оруулахаар бас ингээд ажиллаж байгаа гэдгийг хэлчихье. Баярлалаа.

**Н.Энхболд:** Сүхбаатар гишүүн тодруулъя.

**Ж.Сүхбаатар:** Би аудит энд гүйцэтгэлийн аудит л даа. Тэгэхээр

гүйцэтгэлийн сахилга бол энэ телевизэд алдагдчихсан байж байна, тэгээд санхүү, зохион байгуулалтын доголдолтой байж байна. Тэгээд түрүүн тэр ажлын хэсгийн ахлагч Оюунчимэг гишүүн бол гүнзгий хямралд орчихсон байна гэж байна шүү дээ. Тэгэхээр хямралын үеийн менежмент гэж байдаг. Крайсис менежмент /crisis management/ гэж, комплект менежмент /conflict management/ гээд, зөрчилдөөний менежмент гэж байна. Байгууллагын дотоод уур амьсгал, соёл, сэтгэлгээнд асуудлууд үүсчихсэн байна дотроо. Бас гадна талд байна. Их Хурал, олон нийтийн телевиз, олон нийтийн телевиз дотроо олон нийтийн телевиз үзэгчдийн хооронд. Тэгэхээр бодлого, захиргаа, санхүүжилт гэсэн юмнаас гадна тэр хамгийн гол юм бол энэ юу байгаа байхгүй юу. Соёлын асуудал байгаа юм.

Тэгэхээр энэ асуудал дээр манай гүйцэтгэх удирдлагыг төлөөлж байгаа манай Гэрэл захирал юу бодож, санал хэлмээр байна? Бас энэ дээр бас санал бодлоо хэлэх ёстой байх. Ирж энэ танилцаж байна шүү дээ. Дүгнэлттэй та танилцлаа, тайлантай танилцаж байна. Энэ дээр.../минут дуусав./

**Н.Энхболд:** Монголын Үндэсний олон нийтийн радио, телевизийн ерөнхий захирал Гэрэл. Саявтар Үндэсний зөвлөл хуралдаж бөөн асуудал болж болж байгаад Гэрэл захирлыг шинээр томилсон. Их итгэл, найдвар хүлээж Үндэсний зөвлөл нь арайхийж хэл амаа олж байж хүнээ томилсон байх гэж бодож байна. Бодож, төлөвлөж байгаа зүйлүүд олон байгаа байх. Ажилд нь амжилт хүсье. Тэгээд Сүхбаатар гишүүний асуултад хариулъя. 2 дугаар микрофон. Битгий дар. Наадах чинь цаанаасаа асчихна. 2 дугаар микрофон.

**Г.Гэрэл:** Баярлалаа. Сүхбаатар гишүүний асуултад хариулъя. Монголын Үндэсний олон нийтийн радио, телевизийн төсөв, үйл ажиллагаа энэ 2023 он хүртэл ямар нэгэн төлөвлөгөө, 24 оныхоо үйл ажиллагааны төлөвлөгөөг

зохиож амжаагүй байсан. Энэ нь бол энэ Гүйцэтгэлийн аудитын тайлан дээр гарсанчлан засаглалын хямралтай холбоотой, Үндэсний зөвлөлийн тогтоол нь хэрэгжихгүй байгаад байсантай холбоотой юу гэж би бол харсан.

2024 оны 4 сард бид нар гүйцэтгэх удирдлага ажил аваад төсвөө Үндэсний зөвлөлдөө оруулж байна. Хямралыг даван гарах энэ өрийг хэрхэн яаж барагдуулах, өнөөдрийн байгаа өртэй байгаа мөртөө үйл ажиллагаагаа хэрхэн яаж явуулах вэ гэдэг дээр бид нар саналаа Үндэсний зөвлөлдөө өгсөн байгаа.

2024 оны 4 сарын 1-нд ажлаа аваад, өрөө шалгахад бол яг цаасан дээр 4.2 тэрбум төгрөг, үйл ажиллагаатай холбоотой 4 тэрбум төгрөгийн асуудал ингээд нийлээд 8.4 тэрбум төгрөгийн алдагдалтай ажиллахаар 2024 ондоо харагдаж байна.

Гэсэн ч бид нар бол энэ жил Үндэсний олон нийтийн радио, телевиз Улсын Их Хурлын сонгууль болох гэж байна, наадам болох гэж байна үйл ажиллагаануудыг явуулах хэрэгтэй, хөтөлбөрийн бодлогын дагуу бид нар бас сүлжээгээ шинэчлэх шаардлагатай, менежментийн үйл ажиллагаагаа шинэчлэх шаардлагатай ийм үетэй бол нүүр тулгарч байна гэж хэлж болно. Төлөвлөгөөгөө зохион байгуулаад Үндэсний зөвлөлдөө батлуулахаар өгсөн байгаа.

**Н.Энхболд:** Сарангэрэл гишүүн.

**Д.Сарангэрэл:** Баярлалаа. Би энэ олон нийтийн телевизэд ажиллаж байсан, бас телевиз байгуулж удирдаж явсан хүний хувьд бас зах зухаас нь мэднэ.

Үндэсний олон нийтийн телевизийн тухайд нэг их тийм санхүү, захиргааны хямралд орох гэж тийм том дүгнэлт хийхээр биш л дээ. Тэгээд үйл ажиллагаа нь доголдсон, хямралд орсон, алдагдалд орсон гээд энэ чинь ямар

цементийн үйлдвэр үү? Тэгээд би аудитаас асуух гээд байна. Яагаад санхүүгийн хямралд орсныг нь та бүхэн тодорхойлсон уу? Санхүүгийн эх үүсвэр нь тодорхой шүү дээ. Улсын төсвөөс санхүүждэг цорын ганц телевиз нэг.

Хоёрт нь хураамж авдаг.

Гуравд нь хувийн телевизүүдтэй адилхан реклам явуулдаг, төлбөртэй нэвтрүүлгүүд хийдэг. Төрийн өмчийн үйлдвэрүүдтэй гэрээ хийж их хэмжээний мөнгийг төвлөрүүлдэг.

Тэгэхээр саяын энэ 3 эх үүсвэрийн аль нь доголдоод цалингаа тавьж чадахгүй хэмжээнд очсон юм бэ? Энийг аудит яаж гаргасан энийгээ хэлээдэх. Энэ 3 эх үүсвэрийн аль нь доголдоод та бүхний нэрлээд байгаа тэр том хямралд орчихсон юм? Хямралд ороход хамт олон ямар ч буруугүй шүү. Түрүүн Сүхбаатар гишүүн яг хэлж байна лээ. Энэ Их Хурал, манай Байнгын хороонд бас алдаа байгаа. Тэр Үндэсний зөвлөлийн гишүүдтэй холбоотой асуудал яриад байна. Телевизийн удирдлага Үндэсний зөвлөлийн гишүүдийн хооронд зөрчил байгаагаас тэр захиргааны хямрал гэдэг нь үүссэн гэж.

Тэр хуульд өөрчлөлт орогч оруулах гэж байгаа юм бол Оюунчимэг гишүүнээ Үндэсний олон нийтийн телевиз 15 удирдах зөвлөлийн гишүүнтэй. Энэ Удирдах зөвлөлийн гишүүд дотроосоо хяналтаа хийдэг байхгүй юу. Өөрөө өөрийгөө хэзээ ч хянадаггүй. Хяналт хөндлөнгийнх байдаг. Тэгээд чи эхлээд сонс. Тэгээд хяналт, хяналтын гээд хэдэн хүн гаргачхаад тэд нарынхаа гаргасан шийдвэрийг Үндэсний зөвлөл нь хэзээ ч хэрэгжүүлдэггүй, хүлээж авдаггүй. Хяналтын зөвлөл нь дүгнэлт гаргахаар зэрэг тэр хүнийгээ огцруулна гээд Төрийн байгуулалтын байнгын хороонд гарын үсгээ зураад явуулж байгаа. Би тэрийг мэдэж байгаа. Тэнд шударга сэтгүүлч ажиллаж байгаа шүү дээ. Оюун-Эрдэнэ тэр Хяналтын зөвлөлийг ахлаад. Тэгээд энэ хүн рүү дайрсан баахан үйл

ажиллагаа явж байна лээ. Тэгж болохгүй. Ингэж дампууруулж ерөөсөө болохгүй.

Тэгээд сая одоо Үндэсний телевизээ аваръя, би энэ нэвтрүүлгийг үздэг, хамгийн миний үздэг юу гээд тийм өрөвдмөөр сошиалын юм явуулж байна лээ. Энд хамгийн гол нь удирдлагын төлөвлөгөө, хамт олондоо итгэл, урам зориг өгсөн, хамтарч энэ нөхцөл байдлаас гарах тухай асуудал болохоос биш манайх мундаг гээд сошиалаар мянга хашихраад энэ та нарын яриад байгаа энэ хямрал чинь, энэ нэр хүнд чинь өсчихгүй шүү дээ.

Тэгэхээр зэрэг би Аудитын ерөнхий газар бодит дүгнэлтийг тоотой, баримттай гаргах хэрэгтэй. Ерөнхийдөө л ер нь хямралд орсон байна. Үндэсний зөвлөл удирдлагын хооронд зөрчил гарсан байна.

Одоо тэгээд ийм хэцүү байдалд орсон гээд их ийм сүртэй ингээд номууд гаргачхаад, тэгээд би миний асуултад тодорхой хариулаад аль. Санхүүгийн хямрал юунаас болсон байна нэг? Засаглалын хямралыг та бүхэн юутай холбож үзэж байгаа юм? Засаглал гэдэг чинь хэдэн удирдлагын асуудал шүү дээ ер нь. Үндэсний зөвлөл чинь өөрөө удирдлага. Тэгэхээр ерөөсөө удирдлага хоорондын үл ойлголцол, эрх ашгийн зөрчил, юу булаацалдсан юм мэдэхгүй тийм асуудал байна. Тэрийг нь та бүхэн гаргаад ирсэн юм уу? Оюунчимэг гишүүн тухайлбал ажлын хэсэг ахалсан юм бол энэ дээр та нар ажлын хэсэг чинь ямар дүгнэлт хийж байгаа юм? Бас хариул.

Хоёрдугаарт, Аудит хариулаад орхи. Тоо баримттай хариулна шүү. Ерөнхийдөө энэ Байнгын хороон дээр гишүүд ярьж байгаатай адилхан хямралд орсон байна гэдэг тэр үгийг давтах хэрэггүй. Тэгээд би хариултаа авчхаад тодруулъя.

**Н.Энхболд:** 5 номер. Тэндээс хариулчих. Нэрээ хэлээд, албан тушаалаа хэлээд.

**Я.Самбууням:** Та бүгдэд энэ өдрийн мэндийг хүргэе. Үндэсний Аудитын газар Аудитын нэгдсэн удирдлага зохицуулалтын газрын захирал тэргүүлэх аудитор Самбууням байна. Сарангэрэл гишүүний асуултад хариулъя.

Манай тайлангийн 2.6 дугаар хэсэг дээр тодорхойлсон байгаа. Үндэсний олон нийтийн радио, телевиз 2021, 22, 23 онуудад бол өөрийнхөө орлогын төлөвлөгөөг бол батлуулахаар бол Үндэсний зөвлөлтэй саналыг оруулсан байдаг. Нийт орлогын төлөвлөгөөний 53.5 хувь, 53.5 хувиас 65.9 хувийг нь бол үндсэн орлого бол буюу өөрийн орлогоор бүрдүүлдэг.

34-46 хувийг нь бол улсын төсвийн санхүүгийн дэмжлэг эзэлдэг байгаа юм.

Бидний гаргасан дүгнэлтээр төлөвлөсөн зардлаас бол орлогын хэмжээ бага байдаг. Яагаад гэхээр зэрэг 2021 оны байдлаар бол нийтдээ улсын төсвөөс дэмжлэг авахаар 17.7 тэрбум төгрөгийн саналыг хүргүүлснээс 6.5 тэрбум төгрөгийн төсөв батлагдаж, санхүүжилтийг авсан байдаг.

2022 онд л 17 тэрбум төгрөгийн төсвийн саналыг хүргүүлснээс 5.3 тэрбум төгрөгийн төсвийг авсан. 2023 оны байдлаар 16 тэрбум төгрөгийн саналыг хүргүүлснээс 5.9 тэрбум төгрөгийн санхүүжилтийг авсан байдаг.

Үүнээс дүгнэж хэлэхэд үйл ажиллагааны зардал нь бол орж ирж байгаа орлогоосоо давсан. Үүнээс болоод алдагдал гарах нөхцөл бүрдсэн. Гол шалтгаалж байгаа юм бол улсын төсвөөс авах санхүүгийн дэмжлэгийг төлөвлөсөн хэмжээнд баталж өгөхгүйгээс шалтгаалж төсвийн доголдол үүссэн байна гэсэн дүгнэлтийг өгсөн байгаа.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

**Н.Энхболд:** Оюунчимэг гишүүн.

**М.Оюунчимэг:** Аудит сая гол шалтгааныг хэлчихлээ. Гэхдээ мэдээж бид нар энэ улсын төсвөөс нөгөө санхүүжилтийг тусгаж өгөхдөө би хэлээд байгаа Сангийн сайдын нөгөө багц руу ороод өгчихөөр энэ нөгөө бараг улсын төсвийн дэмжлэг гэхээсээ илүүтэй эд нарт санхүүгийн өөр дэмжлэг үзүүлээд байгаа юм шиг ингээд энэ аягүй гажуудал үүсээд байгаа юм.

Тэгэхээр бид нар энийг засаад тэр Сангийн сайдын багц руу биш, энэ төсвөөс олгож байгаа санхүүжилтийг ямар замаар яг энэ Олон нийтийн радио, телевиз авдаг гэдгийг тэр BBC, CNN шиг маш тодорхой болгох ёстой. 4 тэрбумыг баталсан бол 4 тэрбумаа энэ хүмүүс цаг хугацаандаа яг авдаг байх ёстой.

Тэгэхгүй бол асуудлууд байгаа. Үүнийг Хяналтын зөвлөл нь ч үүнийг өмнө нь хэлсэн байгаа юм. Тэгээд одоо нийгмийн даатгалын шимтгэлийн санд 4.4 тэрбум төгрөгийн өр үүсчихсэн. Энэ өр үүссэн шалтгаан нь өмнөх захирал Бүрэнбаатар нь бас халагдаад л, буцаж ороод л ийм юм байхдаа ажилчдынхаа цалинг Үндэсний зөвлөлдөө оруулж хэлэлцүүлэхгүйгээр шууд тэр эндээс мөнгө гаргаад нэмэгдсэнээс болоод одоо энэ өр нь үүсээд, дахиад нөгөө хүмүүс нь нэмэгдсэнээрээ цалингаа авах гэхээр тэр цалингаа Сангийн яамнаас очиж авна даа тээ өмнө нь нэмэгдсэн бол тэр нэмэгдлээрээ л авна шүү дээ. Тэгтэл тэрний зөрүү гээд асуудал энд ингээд үүсчхээд байгаа нь өөрөө санхүүгийн хямрал нэгдүгээрт.

Хоёрт, Үндэсний олон нийтийн радио, телевиз ганцаархнаа хураамж авч байгаа цорын ганц телевиз биш болчихсон. Өргөн нэвтрүүлгийн тухай хуулиар арилжааны 18 телевиз одоо бас хураамж авч байгаа. Тэгэхээр эд нарын нь маань хураамж маань 2005 оны тэр 1



дүгээр сард буюу одоогоос бараг 20-иод жилийн өмнө баталсан тэр журмаараа л яваад байгаа учраас хураамжийнхаа хувь хэмжээг нэмэх шаардлагатай байна гэдэг тийм хүсэлтийг удаа дараа өгч байгаа юм байна лээ. Тэгэхээр бид нар бас энэ асуудлыг шийдэх нь зөв байх гэж бодож байгаа. Олон нийтийн радио, телевиз бол улс оронд зайлиггүй байх ёстой. Бид үүнийгээ, түрүүн Сүхбаатар гишүүн, Сарангэрэл дарга энэ тэрийн хэлдэг шиг чадваржуулаад, бас энийгээ хөгжүүлээд явах нь улсын тусгаар тогтнолын асуудал гэж бодож байгаа.

Тийм учраас энэ асуудлыг өнөөдөр Төрийн байгуулалтын байнгын хороо бас хаврын чуулгандаа багтааж хэлэлцэж байгаа гэдгийг бас хэлье. Баярлалаа.

**Н.Энхболд:** Сарангэрэл гишүүн тодруулна.

**Д.Сарангэрэл:** Үйл ажиллагааны зардлыг Сангийн яам баталж өгөөгүй түүнээс болоод ингээд хямралд орсон гэж байна. Аль Сангийн сайдын үед ийм асуудал болсон бэ? Хариулт авъя.

Хоёрдугаарт, Хяналтын зөвлөлөөс асуух гэж байна би. Хяналтын зөвлөл төлөвлөгөөг нь баталж өгөхгүй бас үйл ажиллагааг нь доголдуулсан байна. Хяналтын зөвлөл ер нь Удирдах зөвлөлтэйгөө яаж ажиллаж байгаа юм? Тэнд ер нь ямар асуудал байгааг Хяналтын зөвлөл яаж дүгнэж байгаа юм? Тэрийг нэг хариулаад аль.

**Н.Энхболд:** Самбууням дарга 5 номер. Дараа Оюун-Эрдэнэ бэлдэж байгаарай.

**Я.Самбууням:** Сарангэрэл гишүүний асуултад хариулъя. Самбууням Үндэсний Аудитын газар.

Сангийн сайдын багцад бол Үндэсний олон нийтийн радио, телевизийн төсөв бол хуваарилагдан батлагдаж эндээс бол санхүүжилтээ авч ажиллаж байгаа. Төсвийн хувьд бол

хүргүүлсэн саналын бууруулж баталж байгааг бол энэ бол Сангийн сайд дээр нь хамааралтай юм уу, Их Хурал дээр энэ төсөв батлах дээр буурч батлагдаад байгаа юм уу? Үүний шалтгааныг бол бид тогтоож чадаагүй. Ер нь бол Үндэсний олон нийтийн радио, телевизэд бол хамгийн сүүлд 2017 онд хөрөнгө оруулалтын санхүүжилт төсөв хэлбэртэйгээр 9 тэрбумын санхүүжилт өгсөн. Үүнээс хойш бол давтан санхүүжилт бол буурч батлагдаж ирсэн байгаа.

Сангийн сайдын хувьд бол 2021 оноос хойш бол одоо Сангийн сайд.../минут дуусав./

**Н.Энхболд:** 7 номер.

**Д.Оюун-Эрдэнэ:** Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Би Хяналтын зөвлөлийн дарга Оюун-Эрдэнэ байна.

Одоо үйл ажиллагаа явуулж байгаа Хяналтын зөвлөл 2022 оны 9 сараас яг шинэ багаараа ажилласан. Энэ хугацаанд нийтдээ энэ томилогдсоноосоо хойш нийтдээ 19 удаа бид нар хуралдаж асуудлуудыг хэлэлцсэн. Тэгээд төлөвлөгөө баталж өгөөгүй гэдэг асуудал дээр 22 он дээр тийм асуудал байгаа байх гэж бодож байна. Тэгээд 22 оны үйл ажиллагааны төлөвлөгөө болон үзэл баримтлалыг өмнөх гүйцэтгэх удирдлагаас оруулж ирсэн байгаа. Үүний Үндэсний зөвлөлөөс батлагдаагүй байгаа шалтгаан нь Үндэсний зөвлөл хурлаа хийгээгүй, бас Ерөнхий захирал бас тодорхой бус байдалд орсон. Энэ байдалтай үүдэлтэйгээр Үндэсний зөвлөлөөр батлагдаагүй. Хяналтын зөвлөлөөс ер нь бүх асуудлаа яг цаг хугацаанд нь хэлэлцээд хуулийн дагуу бүх үнэлэлт, дүгнэлт, зөвлөмжөө гаргасан байгаа. Энэ таширамд бас тайлбар өгч болох уу?

**Н.Энхболд:** 7 номер. 1 минут нэмээд өгчих.

**Д.Оюун-Эрдэнэ:** Манай Хяналтын зөвлөл нь 2, 3 гишүүнтэй байдаг. Би Үндэсний зөвлөлөөс давхар сонгогдож орж ирээд тэгээд Хяналтын зөвлөлийн даргын ажил хийж байгаа. Манай Хяналтын зөвлөлд ажилладаг хоёр маань доктор, профессор яг энэ санхүү, менежментээр мэргэшсэн ийм хоёр хүн ажилладаг. Тэгээд энэ хугацаанд бас энэ Үндэсний аудитын газрын хийсэн энэ шалгалтыг би их хуулийн үндэслэлтэй бас их бодит байдалд сайн хийсэн тийм дүгнэлт гарсан гэж бодож байгаа юм.

Тэгээд засаглалын хямрал үүссэн гэдэг асуудал дээр бүгд ярьж байгаа. Тэгэхдээ энэ засаглалын хямрал үүссэн шалтгаан нь Үндэсний зөвлөл дээрээ байгаа гэж ойлгодог. Тэгээд Хяналтын зөвлөлийн дарга болсноосоо хойш Үндэсний зөвлөлийн гишүүдийн хариуцлагыг сайжруулах үүднээс Олон нийтийн телевизийн хуульд заасан Хяналтын зөвлөлийн бас эрх, үүргийг биелүүлэхийг хичээж ирж байгаа. Энэтэй холбоотойгоор бас бас хамт олны шаардлагатай холбоотойгоор 1 гишүүн дээр зөвлөмж гарсан байгаа. Хурлын ирц 8 сар тасалдсан гэдэг шалтгаанаар. Тэгээд энэ маань бас Үндэсний аудитын тайлан дээр бас хуулийн үндэслэлтэй бас гэдэг тийм дүгнэлт өгсөн байгаа.

**Н.Энхболд:** Гишүүд асуулт асууж. Одоо үг хэлнэ. Тийм, Байнгын хороо гишүүдээс саяын хоёр танилцуулгатай холбогдуулаад үг хэлэх гишүүд байвал нэрээ өгье.

Сүхбаатар, Оюунчимэг,  
Сарангэрэл.

Сүхбаатар гишүүн.

**Ж.Сүхбаатар:** Тэгэхээр түрүүн би нөгөө хэлснээ гүйцээгээд хэлэхэд гүйцэтгэх удирдлага байж байна. Ер нь яах вэ Монголд бид нар чинь тийм баалаад л, буруутгаад л, уурлаад л ингээд л яваад байдаг. Гэтэл асуудлын шийдэл бас тэр биш л дээ. Тэгэхээр одоо манай

Гэрлээ захирал юу яах хэрэгтэй Үндэсний зөвлөлтэйгөө хамтарч ажиллаад, тэр тодорхой хэмжээ яах вэ том дүгнэлтүүд байж магадгүй. Түрүүн Сараа гишүүн бас хэллээ хэт дампуурах гэж байгаа юм шиг ингээд байдалд орсон юм байхгүй. Санхүүгийн доголдол бол үүсчихсэн юм байна. Хамт олны дотоод уур амьсгалд асуудлууд байна.

Тэгэхээр энэ асуудлыг, байгууллагын соёлыг яаж бий болгох вэ? Хүмүүсийн майнд /mind/ тэр үүсээд байгаа тэр бухимдлууд эд нарыг бас ингээд янзлахын тулд ажиллах хэрэгтэй юм байна. Тэр Үндэсний зөвлөлийн ч гэсэн гишүүд бас хүн байна хариуцлага гэж ярихаас гадна тэр хариуцлагаа өгөхөөсөө өмнө юмаа янзлах хэрэгтэй шүү дээ. Одоо би ч гэсэн Их Хуралд нэр дэвшихгүй гэгчихсэн ч гэсэн Улсын Их Хурлын үйл ажиллагаандаа идэвхтэй оролцоод л хаалгаа зөөлөн хаагаад л төрийнхөө юмнаас гарах ёстой гэж бодож байгаа хүн байхгүй юу жишээлбэл. Тэрэнтэй адилхан одоо энэ Үндэсний зөвлөлийн ч гэсэн зарим улсууд ингээд буян үйлдээд гэдэг шиг ингээд хамт олон бүтээлч уур амьсгал үүсээд тэр зөрчилтэй байгаа хүмүүс ч гэсэн хоорондоо хамтарч ажиллаад энэ чинь нэг хамт олон байхгүй юу даа. Үндэсний телевиз тэрнээс дотор байгаа асуудлуудыг хэн нэгнээр, Их Хурал шийднэ, Засгийн газар шийднэ, эргэж шийднэ гэх юм бол шийдэхгүй.

Одоо байгаа яг Үндэсний зөвлөл, Хяналтын зөвлөл одоо энэ аудитын дүгнэлт гарчихсан байж байна, тэгээд өөрөө гүйцэтгэх удирдлага байж байна. Тэр Сангийн яам байдаг юм бол ингээд уулзалтууд л хийх ёстой. Бид нар бусдын тухай дандаа ингээд хөндлөнгөөс яриад байдаг байхгүй юу. Тэгж гэнэ, ингэж гэнэ, тэгсэн байна тэгвэл яг энэ дотор байж байна шүү дээ. Уялдаа холбоо засаглалд оролцож байгаа уялдаа холбоо байхгүй байна гэж байна. Монголын зовлон бол бие биетэйгээ уулздаггүй байхгүй юу. Уулздаггүй тэгээд л сургаар тэгчихсэн юм байна лээ.

Худлаа гэвэл тийм гээд л ингээд л баримт ярьж байна гээд. Нүүр нүүрээ хараад л ярих ёстой байхгүй юу даа.

Одоо та бол жишээлбэл энэ Үндэсний зөвлөлд болон бусад улсуудтай нэг бүрчилж уулзах хэрэгтэй. Тэгээд протокол бичих хэрэгтэй. Бүүр протоколгүй уулзалтууд ч хийж болно шүү дээ. Ер нь ийм юман дээр нь үнэхээр та бид нарын санал зөрөлдөж байна, ийм юман дээр санал нийлж байна. Одоо үндэсний телевизээ аваръя гэдэг хөдөлгөөн рүү орж болохгүй шүү дээ. Тийм, энэ чинь ямар юм л бол аварна гэдэг ийм байдал руу байж болохгүй.

Тэгэхээр доголдол байгаа юм бол доголдлоо хэвийн байдалд оруулахын тулд санхүүгийн талаас нь анхаараад явах ёстой. Аль болохоор улс төрчдийг татан оролцуулахгүй байхыг хичээх хэрэгтэй. Татан оролцуулахгүй байх. Энэ чинь хуульд засна гээд ингээд явах юм энэ чинь бол бүтэхгүй одоо бол. Дараагийн шинэ Их Хуралд та нар харин ултай, суурьтай юмаа бэлдчих хэрэгтэй. Шинэ Их Хурал үүнийгээ шинэ улсууд нь аваад явна биз.

Ямар ч байсан одоо байгаа хэдтэйгээ зөрчилдөж байгаа улсуудтайгаа хамтарч ажиллах гэж оролдоод, одоо тэр энэ үзэж байгаа ч гэсэн улсууд Үндэсний зөвлөлийн улсууд сэтгэлгүй тийм дургүй юм бол ядаж гай болохгүй байх хэрэгтэй энэ хэддээ. Ингээд оролцдоггүй юм бол ядаж энэ хэдийгээ ажилд нь саад болоод, илүү дутуу юм яриад байхгүй буян үйлдэх хэрэгтэй л дээ. Энэ чинь Үндэсний телевизийн зөвлөлийн гишүүнээр орсон түүх шүү дээ. Тодорхой хугацаатай ордог. Тэгээд гардаг хорвоо. Гарахдаа хаалгаа зөөлөн хаах хэрэгтэй л дээ. Гараад зүхээд муу хэлчхээд гарч хэрэггүй, бусдад саад болж хэрэггүй.

Тэгэхээр би бол энэ утгаараа энэ сонгуулийн бөгсөн дээр яг энэ тайлан, дүгнэлт хэлэлцэж байгаа учраас ерөөсөө бид нарын зовлон бол дотоод уур

амьсгалынхаа бие биеэ давж гарах гэсэн, бие биеийгээ муу хэлж байгаа гэж. Тэрийгээ зөндөө хэлчихлээ шүү дээ. Муу хэлдэг бол хэлчихлээ. Зүхдэг бол зүхчихлээ, араас нь юм цацдаг бол цацчихлаа, ярьдаг бол ярьчихлаа.

Тэгэхээр одоо ямар ч байсан телевизийнхээ юмыг нэг зохих түвшинд, одоо бол хөгжүүлэх тухай асуудал бид ярихгүй болж байна. Нөгөө Шинэ сэргэлтийн бодлогын эхний 10 жилд чинь саад болоод байгаа хүчин зүйлээ арилгана гэсэн аягүй зөв зорилттой байдаг байхгүй юу. Тэр шиг манай одоогийн удирдлагын гол зорилт бол тогтворжуулах тухай асуудал ярьж байгаа. Хөгжүүлэх биш. Хөгжил бол тогтворжсоны дараа явагдана.

Тэгэхээр тогтворжуулахын тулд юу юм гэхээр зэрэг уялдаа холбоогүй, хоорондоо уулздаггүй, учирдаггүй хараал зүхэл хийгээд, бие биедээ гомдоод байгаа улсуудыг янзлахаас л эхэлнэ шүү дээ. Тэгээд болохгүй бол арай олонх хэсгийг нь татаж авах хэрэгтэй. Цалингаа цавуугаа өгье гэж байгаа бол энэ чинь тал талаасаа эвлүүлээд яаж өгөх вэ гэдгээ бодох хэрэгтэй. Яг бүх дотоод энэ телевизэд үүсээд байгаа зовлонг гаднын талаас нь шийдүүлнэ гэвэл тэр бас хэцүү. Тэгээд ямар ч гэсэн том утгаар нь ярих юм бол нөгөө үндэсний эвлэрэл гэдэг шиг юм байж байж юмнаас гардаггүй биз дээ? Тэр шиг дотоодын уур амьсгалынхаа зохицуулалтаа сайн хийж байж урагшлах ёстой.

Сүүлийн үеийн тэр Харвардын судалгаан дээр ч гэсэн ер нь улс төрчид, лидерүүд бодлого их анхаараад байна. Буруу байна. Компани, том компаниуд. Хүндээ анхаар. Хүмүүсийн майнд/ mind/ дээрээ анхаар, хүмүүст сэтгэл ханамжгүй юм уу зөрчлүүд нь нүүр тулсан уулзалтуудаас л дутаад байна гээд байгаа байхгүй юу. Холдчихсон. Тэгээд л тэрүүгээр тэнд буланд хүн тэр хүний тухай яриад л, тэнд буланд нэг хүний тухай юм яриад л. Нүүр, нүд нүдээ харж ярих юм бол асуудал шийдэгддэг

гээд сая сүүлд гарчихсан байгаа байхгүй юу. Тэгэхээр би энийг бас та хэддээ л энэ.../минут дуусав./

**Н.Энхболд:** Сүхээ гишүүнд баярлалаа. Оюунчимэг гишүүний микрофоныг өгье.

**М.Оюунчимэг:** Би Үндэсний зөвлөлийн дарга Монсор даргыг сайн анхаарлаа хандуулаач гэж хэлмээр байна. Яагаад гэвэл олон нийтийн радио, телевиз бол энэ манай улсын юм хэлээд байгаа тусгаар тогтнолын баталгаагийн нэг учраас маш сайн хөгжүүлж, тогтвортой байх ёстой.

Тэгэхээр тэр санхүүжилттэй холбоотой асуудал Сангийн яамнаас нөгөө төсвийн мөнгийг татаас маягаар олгож байгаа нь Сангийн сайдын буруутай асуудал огт биш шүү. Манай зарим гишүүд маань бас тэгж ойлгоод байна. Сангийн сайд энд ямар ч хамаа байхгүй. Хамгийн гол нь нөгөө эд нар маань цаг хугацаандаа Үндэсний зөвлөл рүүгээ оруулаад тэгж ярихгүй бол гүйцэтгэлийн аудит ч гэсэн энэ Сангийн сайд нараасаа биш хамгийн гол нь манайх тэр энэ санхүүжилтийг яаж олгох механизм тодорхойгүй байгаагаас болоод эд нар Сангийн яамны үүдэнд очиж суугаад, одоо тэдийг ингэчих, одоо ингэчихдэг гэдэг болчихсон. Уг нь тэгдэггүй байсан шүү дээ хуучин.

Тэгэхээр энийг бид зайлигүй, яаралтай засах ёстой. Засгийн газар дээр засах уу, юун дээр засах вэ энийгээ хийх ёстой. Үндэсний олон нийтийн радио, телевизийн ажилчдын цалин бага гэвэл үнэхээр бага учраас арилжааны телевизүүд энэ чадварлаг боловсон хүчнүүдийг өндөр үнээр цохиод авчхаад байгаа тохиолдолд зайлигүй нэмэх ёстой. Тэгээд сая цалингаа нэмсэн юм байна лээ.

Гэхдээ нэмэхдээ энэ орлогоос ингэж нэмнэ, ийм эх үүсвэрээс ингэж гаргана гэсэн ямар ч тооцоо, судалгаа байхгүй. Тэр тооцоо, судалгааг Үндэсний

зөвлөлдөө ч оруулж танилцуулаагүй. Үндэсний зөвлөл, Хяналтын зөвлөл нь ямар эх үүсвэрээс та бүхэн энэ цалинг нэмэх ч байна, яаж энэ тооцоо судалгааг яах вэ, яаж энийг нөхөх вэ, нийгмийн даатгалын шимтгэлээс энэ болохгүй ч гэдэг юм уу тэгж хяналт тавих үүргээ биелүүлээгүй байхгүй юу. Одоо бол ингэж болохгүй.

Тэгэхээр би Гэрэл даргыг бас мерит зарчмаар багаас нь телевизэд ажиллаж байсан хүн байна. Нээлттэй сонсголоор сая удирдлагууд нь томилогдсон. Сая хэлж байгаа тэр эв нэгдэлтэй энэ хамт олныг ажиллуулж, ажиллах нөхцөл бололцоог нь сайжруулж, мундаг сайхан контентуудаар алдартай шүү дээ манайх. Гэтэл энэ зогсчихсон. Тэгээд энэ тэрийг буцааж сэргээх ёстой. Чадварлаг хүмүүсээ буцааж татаж авах ёстой. Цалин хөлсийг нь өгсөн шиг өгөх хэрэгтэй гүйцэтгэл дээр нь. Бид нар чинь, би лав ажилладаг байхдаа цалингаа авна, цалин дээрээ хийсэн ажил минь чанар болоод урамшууллаа аваад үнэхээр бас хангалттай байдаг байсан.

Гэтэл одоо ийм инфляц ямар болчихсон байгаа билээ, үнийн өсөлт ямар байгаа билээ. Гэтэл тэр үед авч байснаас бага юмыг өнөөдөр аваад Алтангэрэл гэж тоймч жишээлбэл хэдэн жил энд хөөрхий үнэнчээр ажиллаж байна. Ганцхан жишээ.

Тэгэхээр ийм хүмүүсээ хайрлах хэрэгтэй, ажиллах хэрэгтэй та нар маань. Би Гэрэл даргад, Ерөнхий захиралд итгэж байна шүү. Энд сайн ажиллах хэрэгтэй. Үндэсний зөвлөлийн дарга маань одоо яг ингэж бодлогоо зангидаад, ажлаа хийвэл хийсэн шигээ хийж чадахгүй бол та саналаараа ажлаа өгөөд, чаддагт нь энэ юмаа хийлгээд явчихсан нь дээр байх шүү.

Яагаад гэвэл би бас ажлын хэсгийн ахлагчийн хувьд хэлчихье. Бүх ажлын хэсгийн гишүүдийн дүгнэлт ч энэ дээр буусан шүү. Тэгээд өөрөө хөөрхий

юмаа бас бодлогоо зангидаж чадахгүй, нөгөө гишүүд нь үгэнд нь орохгүй, өөрөө нэг шийдвэр гаргаад л, дараа нь гаргасан шийдвэрээсээ өөрөө буцаад л. Тэгээд байхаар чинь яаж Үндэсний олон нийтийн радио, телевизийн ажил явах юм. Болохгүй шүү дээ. Иймэрхүү зүйл дээр онцгой анхаарч ажиллах ёстой шүү гэдгийг хэлье. Баярлалаа.

**Н.Энхболд:** Сарангэрэл гишүүн. Дараа нь бид нар бас тогтоолын төсөл ярих ёстой. Саналаа хэлье Сарангэрэл гишүүн.

**Д.Сарангэрэл:** Ер нь би Олон нийтийн радио, телевиз дээр тэр Үндэсний зөвлөл, тэр радио, телевизийн удирдлага хоорондоо учраа олно биз дээ. Одоо хэлэх гэж байгаа зүйл та бүхний энэ зөрчил, хэрүүл уруулын чинь цаана уран бүтээлчид хохироод байгаа гэдгийг хэлье. Уран бүтээлчдийн цалин мөнгийг нэмэх чиглэлд Улсын Их Хурал хуруугаа ч хөдөлгөөгүй. Тэрийг одоо дотооддоо ямар нэгэн байдлаар шийдсэн байх нэг.

Хоёрдугаарт, Аудитын дүгнэлт, ажлын хэсгийн дүгнэлт, Гэрэл дарга бас өөрөө хэлчээж байна нийгмийн даатгалд бид нар өртэй гэж. Энэ бол энгийн хэлэх зүйл биш шүү дээ. Яагаад гэвэл нийгмийн даатгалын шимтгэл гэдэг маань өөрөө давхар Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг илэрхийлж байдаг. Нийгмийн даатгалын шимтгэлийн өртэй байгаа бол олон нийтийн радио, телевизийн уран бүтээлчид эмнэлгийн тусламж, үйлчилгээ авч чадахгүй байна гэсэн үг. 100 хувь кармагаасаа мөнгөө төлж байгаа.

Ийм нөхцөл байдалд өнөөдөр Үндэсний зөвлөл болон радио, телевизийн удирдлага хамтраад энэ асуудлаас гарах арга хэмжээг хамгийн түрүүнд авах ёстой. Хүний эрүүл мэндээс илүү чухал зүйл гэж байхгүй шүү дээ. Наад телевиз, радиогийн орчин чинь өөрөө хорттой нөхцөл шүү дээ. Тийм болохоор энэ дээрээ анхаарах хэрэгтэй гэж.

Хоёрдугаарт, 8 сар хуралдаа ирээгүй Үндэсний зөвлөлийн гишүүн байна шүү дээ. Тэгээд энэ хуульдаа зааж өгөх хэрэгтэй л дээ. Ирээгүй бол одоо бид нар яах ёстой юм бэ гэж. Энэ мэтчилэн хуульд өөрчлөлт оруулахад нэлээн анхаарах ёстой. Түрүүний Сүхбаатар гишүүний хэлснээр одоогийн парламент ч арай ч амжихгүй байх. Хяналтын зөвлөл гэдгийг жинхэнэ утгаар нь дотроос нь биш, хөндлөнгийн хяналт байхаар нэгдүгээрт.

Хоёрдугаарт, Энэ уран бүтээлчидтэй холбоотой асуудал дээр нэлээн тийм онцгойлон анхаарах. Дахиад л би Сүхбаатар гишүүнээр жишээ авах гээд байна. Их бодууштай бодууштай зүйлүүдийг хэллээ шүү дээ. Энэ чинь ойлголцол, зөвшилцөл бид нараас илүү та нар ойлголцох ёстой шүү дээ. Нэг байгууллагын нэг эд эс шүү дээ. Үндэсний зөвлөл нь ч тэр, уран бүтээлчид нь, удирдлага, захиргаа нь ч тэр.

Тэгээд тэнд ингээд шууданд хийсэн үхрийн эвэр шиг байгаад, өшөө Их Хурал руу авчраад энэ асуудлаа тавихаар чинь асуудалтай шүү дээ. Дээр нь Үндэсний олон нийтийн радио, телевизийн удирдлагыг хэлэхэд маш их өөрснөө улс төрждөг, Улсын Их Хурлын гишүүдтэй хувьчилж ажилладаг, Үндэсний зөвлөлийн гишүүнд энийг дэмжье, энийг дэмжүүлэхгүй байя гэж өөрсдөө үүнд хутгалдан оролцдог гээд асуудлууд их байгаа.

Тийм учраас нэгэнтээ хуулиараа олон нийтийн радио, телевиз улс төрөөс хараат бус байна гэж байгаа бол Үндэсний зөвлөл нь өөрөө хараат бус байх ёстой. Энэ хараат бус байдлыг хангахад бид нар хууль, эрх зүйн орчныг үүсгэхгүй бол ерөөсөө хүний хүчин зүйл буюу субъективний факторууд маш их нөлөөлж байгаа. Хүссэн, хүсээгүй л тийшээ улс төр ороод байгаа учраас энэ улс төртэй удирдлага бүх зүйл хутгалдчихаад тэнд байгаа уран бүтээлчдийг хохироогоод байгаа асуудлыг бид нар энийг засаж, залруулах

шаардлагатай гэдгийг би хэлье.  
Баярлалаа.

**Н.Энхболд:** Гишүүд хоёр тайлан танилцуулгатай холбогдуулаад асууж, хариулт авч, үг хэлж дууслаа.

Байнгын хорооноос тогтоолын төсөл бэлдсэн байгаа. Гэхдээ эндээс саяын гишүүдийн ярьсан зүйлүүдийг бас нэмж тусгаад бид нар батлах шаардлага гарч байна. Тэгэхээр би тогтоолын төслийг товч уншаад танилцуулчихъя. Тэгээд дээр нь юу нэмэх ёстой вэ гэдэг дээр саналаа хэлье. Тэрийг манай гишүүд бас анзаарч, нэмэхээр зүйл байвал надаа хэлээрэй.

Монгол Улсын Их Хурлын байнгын хорооны тогтоол “Чиглэл өгөх тухай”

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.7 дахь заалт 25 дугаар зүйлийн 25.6 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.6 дахь хэсэг Төрийн байгуулалтын байнгын хорооны “Чиглэл өгөх тухай” 2024 оны 04 дүгээр тогтоолыг үндсэн Төрийн байгуулалтын байнгын хорооноос тогтоох нь:

Төрийн байгуулалтын байнгын хороонд “Чиглэл өгөх тухай” 22 оны 4 дүгээр тогтоолын хэрэгжилт хангалтгүй байгааг тэмдэглэн дээрх тогтоолын хэрэгжилтийг хангах, Үндэсний аудитын газраас Монголын Үндэсний олон нийтийн радио, телевизийн 21, 23 оны үйл ажиллагаанд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланд заасан алдаа, зөрчлийг арилгах хүрээнд дараах арга хэмжээ авч ажиллахыг Монгол Улсын Засгийн газар чиглэл болгосугай.

1.Олон нийтийн радио, телевизийн тухай хуульд заасны дагуу телевизийн нэвтрүүлгийн үйлчилгээний хөлс, түүний хэмжээг шинэчлэн тогтоох, өмнөх аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэх.

2.Монголын Үндэсний олон нийтийн радио, телевизийн үйл ажиллагааг хэвийн явуулахад шаардах санхүүгийн дэмжлэгийг бодит нөхцөл байдалд тулгуурлан төсөвт тусган олгож байх, гүйцэтгэлд нь хяналт тавих.

2.Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, Үндэсний аудитын газраас Монголын Үндэсний олон нийтийн радио, телевизийн 21, 23 оны үйл ажиллагаанд хийсэн гүйцэтгэлийн аудитын ажилд хийсэн алдаа, зөрчлийг энийг бүгдийг нь давтах хэрэггүй юм байна. Зүгээр ингээд явчихъя. Арилгах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Үндэсний олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөл Монсор-д үүрэг болгосугай. Үүн дотор

1.Хуульд заасан эрх зүйн хэм хэмжээ, зарчмыг дагаж мөрдөх хяналт болон удирдлагыг оновчтой хослуулж, байгууллагад үр дүнтэй хамтран ажиллах эерэг соёл, манлайллын төлөвшүүлэх.

2.Хөтөлбөрийн бодлогод хяналт тавих, Радио, телевизийн техник технологийн сүлжээг хөгжүүлэх, техникийн хангамжийн бодлогыг тодорхойлох, чиг үүргээ би хэрэгжүүлж ажиллах эрх зүйн зөрчилтэй тогтоол шийдвэр гаргахгүй байх.

3.Телевизийн нэвтрүүлгийн үйлчилгээний хөлсний хэмжээг шинэчлэн тогтоох талаар тооцоо, судалгааг үндэслэлтэй боловсруулан Засгийн газарт санал хүргүүлж шийдвэрлүүлэх.

4.Хяналт тавих чиг үүрэг бүхий бүтцийн нэгжүүдийн эрх зүйн байдлыг сайжруулж, үр ашигтай ажиллах тогтолцоог бүрдүүлэх.

5.Үндэсний зөвлөлийн албан хэрэг хөтлөлт, архивын үйл ажиллагааг хууль, дүрэм, журамд нийцүүлж хэрэгжүүлэх. Гаргасан шийдвэрийн ил, мод байдлыг хангаж ажиллаж байх.

3 дугаарт, Үндэсний аудитын газраас хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланд заасан алдаа, зөрчлийг арилгах хүрээнд Олон нийтийн радио, телевизийн Хяналтын зөвлөлд дараах арга хэмжээ авч ажиллахыг үүрэг болгох.

Хөтөлбөрийн бодлогоос бусад асуудлаар гарсан Үндэсний зөвлөлийн шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавьж, хэрэгжилтийг хангахад дэмжлэг үзүүлж ажиллах. Мөн алдаа, зөрчлийг арилгах хүрээнд Ерөнхий захирал дараах арга хэмжээ авч ажиллахыг үүрэг болгох. Үүнд:

Үндэсний олон нийтийн радио, телевизийн стратегийн төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж батлуулж, хэрэгжилтийг тайлагнах. Хүний нөөцийн удирдлагыг байгууллагын батлагдсан орон тоо, бүтцэд нийцүүлж хэрэгжүүлэх, удирдах түвшний албан хаагчдыг холбогдох журмын дагуу сонгон шалгаруулж томилох, ажлын цаг ашиглалт, бүртгэлд хяналт тавих, бодит гүйцэтгэлд үндэслэж цалин урамшууллыг олгож байх.

3.Хөтөлбөрийн бодлогыг хараат бусаар хэрэгжүүлэх, дүн шинжилгээ хийх, хуульд заасан нэвтрүүлгийн чиглэлүүдийг тэнцвэртэй байхаар төлөвлөх, зар сурталчилгааг хуулиар тогтоосон хэмжээнээс хэтрүүлэхгүй байх.

4.Реклам, зар сурталч сурталчилгаа захиалгат нэвтрүүлгийг хэрэгжүүлэхтэй холбоотой дүрэм, журмыг боловсронгуй болгох, түүнд тавих дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлж сайжруулах.

5.Үл хөдлөх хөрөнгийн эрхийн гэрчилгээг хууль, эрх зүйн шаардлагад нийцүүлж авах дахин үнэлгээ хийлгэж, стандартын дагуу бүртгэж тайлагнах хөрөнгийн ашиглалтыг сайжруулж, үр ашгийг нэмэгдүүлэх.

6.Цахилгаан, дулааны төвлөрсөн дэд бүтцийн системийн ачаалал, ашиглалтын зардлыг хянаж, бууруулах талаар арга хэмжээ авч хэрэгжүүлэх.

7.Холбогдох хууль болон журамд нийцүүлэн худалдан авах ажиллагааг зохион байгуулах, Шилэн дансны тухай хуульд заасны дагуу мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулж аудитаар өгсөн зөвлөмжийг төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх.

Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн байгуулалтын байнгын хороонд даалгасугай гэсэн ийм төсөл байгаа. Энэ дээр нэмээд сая тэр гишүүдийн гаргасан саналуудыг тусгая. Энэ дотор би зүгээр ийм зүйлүүдийг анхаараасай гэж бодож байна. Зарчмын хувьд үүнийгээ хэдүүлээ баталчхаад, тэгээд сая гишүүдийн орсон зүйлүүдээ ерөнхийдөө агуулгын хувьд, үзэл баримтлалын хувьд таарч байгаа. Тэгэхээр нэмээд баталчхаж болох байх гэж бодож байна.

Тэгэхээр ийм байдлууд ажиглагдаад байгаа юм. Үндэсний зөвлөл бол өөрөө биеэ дааж шийдвэр гаргачхаад, ингэх гэж бид нар хууль гаргаж, улс төрөөс ангид байх хууль гаргаж ингэж ажиллаж байгаа юм. Байж байгаа. Тэгэхдээ нэгэнт Үндэсний зөвлөл бие дааж ажиллаад, улс төрийн нөлөөнөөс ангид ажиллана гэдэг бол ерөөсөө дураараа загнах тухай асуудал огт биш юм байгаа юм. Хуультай, дүрэмтэй тэр хууль, дүрмийнхээ л хүрээнд ажиллаж байх ёстой.

Үндэсний зөвлөл болохгүй байгаа, болохгүй байна гэж сая хүмүүсийн амнаас гарлаа шүү дээ. Тэгж үзэж байгаа бол бид нар хуульдаа тэр Үндэсний зөвлөлийн гишүүдийг үнэхээр нөхцөл байдал тэгж үүсээд байвал яаралтай сольдог, боловсронгуй болгодог ийм хуулийн заалтыг нэмж оруулах хэрэгтэй. Тодорхой хугацаанд жишээ нь, Үндэсний зөвлөл шийдвэр гаргаж чадахгүй сая өнгөрсөн хугацаанд чинь

ингээд дотроо хагаралдчихаад, Гүйцэтгэх зөвлөл нь тэгээд сүүлдээ дураараа загнадаг болсон. Үндсэн шийдвэр Зөвлөл шийдвэр гаргаагүй байхад өөрөө Үндэсний зөвлөлийн баталсан төсвөөс илүү мөнгөөр хүмүүсийн цалин суу нэмээд сууж байдаг. Ийм байж болохгүй шүү дээ. Засгийн газар жишээ нь, Улсын Их Хурлаас баталсан улсын төсвөөс илүү мөнгө зараад байдаггүй биз дээ? Яг энэнтэй адилхан байх ёстой шүү дээ. Энэ тохиолдолд яаж байх юм гэдгийг бид нар энэ хуульд бас дараагийн хуульдаа оруулах ёстой юм байгаа юм. Магадгүй энэ удаа бид нар хуулиа гаргаж амжихгүй ч болчих шиг боллоо.

Гэхдээ төрийн бодлого залгамжтай байх үүднээс энэ Их Хурлын тогтоолд бид нар энэ Байнгын хорооны тогтоолд юм оруулаад явуулчихаад дараагийн Их Хурал ч гэсэн энэ урд шалгалт, хийсэн шалгалтуудын дүн, түүнээс гарсан дүгнэлт, түүний дагуу хэрэгжүүлэх ёстой арга хэмжээ гэсэн зүйлүүдийг харгалзаж үзээд энэ хуульд нэмэлт оруулах ёстой.

Өнөөдөр Үндэсний зөвлөлийг бол зүгээр Их Хурал дангаараа мэдээд шийдчихэж байгаа асуудал бас биш. Төрийн бус байгууллагуудаас, холбогдох салбарын байгууллагуудаас саналыг нь авч байгаад тэрний дагуу томилж явуулж байгаа юм. Томилчихсон хойно Улсын Их Хурлын томилчихсон гишүүдээс бүрдсэн Үндэсний зөвлөл нь ажлаа хийж чадахгүй байгаа бол түүнийгээ түргэн сайжруулдаг эрх нь Улсын Их Хуралдаа байхаар бодож бид нар хуулийнхаа төсөлд, хуульдаа нэмэлт оруулах шаардлагатай юм байна. Энэ бол манай Байнгын хорооноос гаргаж байгаа гол дүгнэлтүүдийн нэг гэж ингэж бодож байна.

Түрүүн бас гишүүд хэлсэн. Жишээ нь, Үндэсний зөвлөлийн гишүүн юм уу, дарга нь тэр биш ээ Хяналтын зөвлөл нь дотроосоо байж болохгүй байхгүй юу. Үндэсний зөвлөлөөс тийм ээ? Биеэ

даасан магадгүй тэр хуульдаа өөрчлөлт оруулаад Үндэсний зөвлөлийн хэн томилдог, тэрний хажуугаар Хяналтын зөвлөлийг нь бас Улсын Их Хурал дээр тогтдог байвал илүү их бие биеэсээ шалтгаалахгүйгээр, бие биеийнхээ ажилд орохгүйгээр биеэ даагаад шийдвэр гаргаад явдаг ийм тэгээд эрх, үүргийн хуваарилалтыг нь их зөв хийгээд өгчихсөн ийм хууль гаргах шаардлагатай болж байна. Энэ талын заалтыг бас бид нар жишээ нь, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлага байна. Ингэхдээ ийм ийм зүйлүүдийг анхаарах хэрэгтэй байна гэдэг юмыг нь өнөөдрийнхөө тогтоол дотор бас биччихэд дараагийн Их Хуралд хэрэг болох болов уу гэсэн ийм бодолтой байна.

Үндэсний зөвлөлийн тогтоол хэрэгжихгүй байсантай холбоотойгоор Гүйцэтгэх зөвлөлийн ийм зүйлүүд, гүйцэтгэх удирдлагын зүгээс ийм юм гаргаж байсан байна гэж өнөөдөр ажлаа хийж байгаа Гүйцэтгэх зөвлөлийн дарга буюу Ерөнхий захирал хэлж байна. Энэ бас үндэстэй. Би түрүүн хэлсэн маргаан гараад эхлэхээр Үндэсний зөвлөл дотроо байр сууриа бэхжүүлэх гэж, эс үгүй бол талцаж хуваагдах юмаа гааруулж байгаа юм уу, яаж байгаа юм? Үндэсний зөвлөлийнхөө шийдээгүй их хэмжээний мөнгөө, цалин хөлсөө нэмэгдүүлж байна гэдэг бол ерөөсөө байж болохгүй зүйл байхгүй юу. Үндэсний зөвлөл нь шийдвэр гаргачихсан байхад, халчихсан байхад, халагдчихсан хүнд шийдвэр гаргаад цалин олгоод яваад байх байсан байгаа шүү дээ. Урамшуулал олгоод яваад байсан байгаа шүү дээ. Ийм байж болохгүй шүү дээ.

Тэгэхээр энэ талаар бас ямар зохицуулалт байх ёстой юм? Тэрийг энэ тогтоолын төсөлд бас санал болгоод үлдээх нь зүйтэй гэж бодож байна. Ер нь тэгээд тэр буруу шийдвэр гаргаж байсан Үндэсний зөвлөлийн шийдвэрээс давсан шийдвэр гаргаж байсан гүйцэтгэх удирдлагын асуудал шалгагдаж байгаа юм байлгүй дээ хууль, хяналтын байна лээ. Хууль хяналтын



байгууллага нь тэгээд шийдвэрээ гаргана биз дээ.

Одоо бид нар Хяналт шалгалтын хуульд нэг зүйл нэмэгдэж орсон юм юу байгаа гэхээр Үндэсний зөвлөлийн гишүүдийг томилохдоо Улсын Их Хурал сонсгол явуулдаг болсон байгаа хуулиар. Энэ нэг шат ахисан хэрэг. Урьд нь бол зүгээр яриад л яачихдаг байсан бол нэлээн сайн хэлэлцэж байж түрүүн Сарангэрэл гишүүний хэлж байгаагаар үнэхээр чадах хүмүүсээ нэлээн шүүж, шахаж байж энийг яахгүй бол бас энэ удаагийн ажилласан Үндэсний зөвлөл дотор зөрчилдөөнөөсөө болоод телевизийн ажилд бас тодорхой хэмжээгээр муугаар нөлөөлсөн. Өнөөдрийн энэ аудитын дүгнэлтэд гараад байгаа алдаа, дутагдлуудыг гаргахад нөлөөлсөн тал байгаа.

Тэгэхээр сонсгол хийж эхэлнэ гэдэг бол бас нэг том шат хийгээд дараа нь аль болохоор зөвлөлийн бүрэлдэхүүн маань бас их зөв хүмүүсээс бүрдсэн байх энэ бололцоог нь хангаж өгөх шаардлага байна гэдгийг бас тэр хуулийн тухай юман дээрээ тусгаж өгөх нь зүйтэй болов уу гэж бодож байна. Тогтоолдоо үлдээгээд. Ийм зүйлүүдийг оруулаад нэмэх санал байвал одоо гишүүд хэлчих. Сая ярьсан юмнуудаа оруулчихлаа гэж бодвол саяын зүйлүүдийгээ оруулаад тогтоолоо батлахад бэлэн байна.

Сарангэрэл гишүүн санал.  
Сарангэрэл гишүүн.

**Д.Сарангэрэл:** Баярлалаа. Тогтоолын төслийг үндсэнд нь дэмжиж байна. Би өмнөх удирдлагыг өмөөрөхгүй. Тэгэхдээ 8 сар Үндэсний зөвлөлийн гишүүн ажилдаа ирэхгүй байдаг, ард нь уран бүтээлчдийн амьдрал байж байгаа учраас арга буюу л цалинг нь нэмэхээс өөр аргагүй тийм нөхцөл байдал би үүссэн гэж нэгдүгээрт бодож байна.

Хоёрдугаарт, энэ тогтоолд телевизийн нэвтрүүлгийн үйлчилгээний хөлсний хэмжээг шинэчлэн тогтооно

гэнэ. Энэ нэвтрүүлгийн үйлчилгээний хөлс гэж юу байдаг юм? Үүнийг мэдмээр байх юм?

Гуравдугаарт, тогтоолд нийгмийн даатгалын шимтгэлийн асуудлыг шийдвэрлэх заалт зайлиггүй орох шаардлагатай. Энд бол одоо уран бүтээлчид маш их хохирч байгаа учраас тэр заалтыг хугацаатай үүрэг өгөөд, энийг дараагийн парламентыг хүлээх боломж байхгүй. Яагаад гэвэл дараагийн парламент 7 сараас нааш бүрдэхгүй.

Дахиад энэ 4 дүгээр заалтад байна. Ерөнхий захирал Гэрэл-д арга хэмжээ авахыг гэж энэ. Гэрлийг шийтгэх гэж байгаа юм шиг болчхож. Тэгэхээр зэрэг энд ийм арга хэмжээ авч ажиллахыг Ерөнхий захирал Гэрэл-д үүрэг болгосугай гэж энэ байрыг нь өөрчлөхгүй бол эхлээд би уншаад гэрэлд арга хэмжээ авах гэж байгаа юм байна гэж ойлголоо шүү дээ. Баярлалаа.

**Н.Энхболд:** Сүхбаатар гишүүний микрофоныг.

**Ж.Сүхбаатар:** Туулаа, яагаарай манайхан саяын тэр Байнгын хорооны даргын үгийг, тэр Засгийн газар чиглэл болгох дээр. Засгийн газрын чиглэл өгөх дээр аягүй жул юм байгаа байхгүй юу. Шинэчлэх, хөлс хэмжээ шинэчлэн тогтоод, өмнөх аудит гэж байгаа юм. Одоогийн аудитыг нь хэрэгжүүлэхгүй гэсэн үг. Зүгээр аудитын зөвлөмж хэрэгжүүлэх, тэгээд хяналт тавих гэхчхсэн байгаа байхгүй юу гүйцэтгэл, төсөвт.

Тэгэхээр энэ дээр тэр нөгөө хууль зүйн асуудлуудаа тусгахдаа ер нь энэ олон нийтийн радио, телевизийн ийм л юм нь болохгүй байгаа байхгүй юу. Өөрөө удирдах ёс гэж байдаг юм. Өөрийн удирдлага буюу төрийн бус байгууллагууд өөрийн удирдлагатай гэж. Тэгэхээр энэ ННК, ВВС эд нар чинь тэгээд Засгийн газар нь удирдаад л, Байнгын хороод нь сонсоод л, ингээд л үүрэг даалгавар өгөөд

л, юмыг нь шийдэж өгөөд л ингээд л байдаг юм байхгүй шүү дээ энэ чинь.

Тэгэхээр үндэс энэ дээр бол тэр өөрөө удирдах олон нийтийн радио, телевизийн тэр өөрөө удирдах ёсыг бэхжүүлэх чиглэлээр болон тэр хөндлөнгийн хяналтыг бий болгох чиглэлээр хууль зүйн орчныг шинээр бүрдүүлэх тэр хариуцлагын тогтолцоог бас давхар биелүүлэх тэр юмыг нь энэ Засгийн газартаа оруулж өгсөн тэр Засгийн газарт даалгаад. Тэгээд тэр дотор нь хоёр дахь юман дотор тэр Үндэсний зөвлөлийн гишүүдийн үүрэг, хариуцлагыг тэр Монсор Үндэсний зөвлөлд нь даалгах хэрэгтэй. Гишүүдийн үүрэг, хариуцлага гэж байна шүү дээ энэ чинь.

Ингээд тийм сураггүй өөрсдөө алга болчихсон Үндэсний зөвлөл дотроо өөрөө энэ гишүүн нь өөрөө тэр Үндэсний зөвлөл дотроо өөрөө тайлагнадаг юм уу, Хяналтын зөвлөлдөө тайлагнадаг байх хэрэгтэй. Тэгэхээр Үндэсний зөвлөлийн гишүүний үүрэг, хариуцлагатай холбоотой заалтыг нь энэ дотор бас оруулж өгөх хэрэгтэй. Тэгээд тэр санхүүтэй холбоотой асуудал дээр энэ Гэрэл-д гээд яачихсан юман дээр чинь тэгээд гол юм ер нь тэгээд Сангийн яамны үүд царайчилдаг гээд түрүүн ажлын хэсгийн л юм хэлээд байна шүү дээ. Тэгэхээр тэрийг нь бас яаж анхаарах вэ гэдэг асуудал байгаа байхгүй юу. Засгийн газрын чиглэл дээр алга. Тэгээд үүнийг чинь тодорхой эсвэл зааж өгөх юм уу, яах юм? Засгийн газрын юман дээр нь тэгэхгүй болохоор чинь ингээд бас энэ чинь болж өгөхгүй байна. Санхүүжилт зүгээр гүйцэтгэлд хяналт тавих гээд ингэчихсэн байж байна.

Тэгээд энэ бусад энэ 4 эд нар дээр их тодорхой заачихсан юм нь энэ ингээд жишиг л болчихно доо. Дараагийн Байнгын хороод ийм тогтоол л гаргадаг болно зүгээр. Энийг нэг удаагийн би протоколд тусгаж байгаа нь ингээд түр хугацааны ийм шийдвэр гаргаж өгч байгаа болохоос биш, дараагийн Гэрэл

даргын дараах захирал бас дахиад болохоо байлаа гээд ингээд ийм юм, арга хэмжээ авч өгөөч гээд байвал энэ чинь Үндэсний Зөвлөл байх шаардлагагүй болж байна шүү дээ.

Энэ доторх яг заалтуудын бараг 80 хувь нь уг нь Үндэсний зөвлөлийн л шийдвэр л байхаар л юм байна л даа. Зүгээр гол юм бол бид нарын чинь Засгийн газар мөнгөө аятайхан өгөөдхөөч, олигтой хүн наад Үндэсний зөвлөлдөө томилоод явуулчихаач гэдэг л юм байгаа байхгүй юу уг нь бол. Бусад нь бол уг нь дотоод өөрөө удирдах ёсных нь л асуудал шүү дээ. Хэмжээ хязгаар гэж байхгүй. Мэдээж тэнд ажиллаж байгаа өнөөдөр ажилтан, албан хаагч нар төр байгаа юм биднийгээ анхаарах ёстой л гэж бодож байгаа байх.

Гэхдээ аль ч тохиолдолд Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороо, Улсын Их Хурлын ажлын хэсгүүд удаа дараалан эдний байгууллагуудын үйл ажиллагаанд оролцох нь буруу шүү. Хэзээ, хаана болсноо тэр ННХ, ВВС эд нар дээр чинь хүн гүйж очоод л давхиад ингээд юмыг нь сонсоод онгичоод байдаг байсан юм. Тэр Үндэсний зөвлөлийн дарга нь болохгүй бол Монсор-д нь хариуцлага тооцдог, Үндэсний зөвлөлийн гишүүн нь зөрчил гаргаад байгаа бол тэрэнд нь л бид хариуцлага тооцно уу гэхээс тэр доторх зовлон, жаргалынхаа юмыг өөрсдөө шийдэх ёстой байхгүй юу.

Тэр Сангийн яам юмыг нь ажлаа хийж өгөхгүй бол тэр Сангийн яамных нь холбогдох Сангийн сайдыг нь дуудаж ирээд харин бид энд асууж байх ёстой болохоос биш энд ирж байгаа хүнийг нь загнаад юм уу янз бүрээр суугаад байх хэрэггүй байхгүй юу жишээлбэл. Эсвэл Их Хурлын гишүүн нь асуулга, асуулт тавьж болно тэрний өмнөөс.

Тэгэхээр үүний би зааг, ялгааг нь хэлээд байгаа юм шүү. Энэ нэг тийм энэ удаагийн тийм дэмжлэг үзүүлэх хэлбэрээр Төрийн байгуулалтын байнгын хороо анхаарч байна. Тэрнээс дараа

дараачийн Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга нар, гишүүд ингээд л байсхийж байгаад л тогтоол гаргаад л, байгууллагын ажилд нь оролцоод л, дуудаад л, хараат байдлаа харуулаад л олон түмэн ч гэсэн Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны мэдэлд байдаг телевиз байна гэж буруу бодогдох вий энэ чинь эргээд. Тэгэхээр энэ үүднээс нь ингэж бодож бас протоколд би бас тусгаж байгаа шүү. Дараагийн тэр улсууд ч гэсэн ажлын хэсгүүд бас байгуулж таарна. Шинэ хүмүүс ирэхээрээ бас л тэгээд л энэ чинь моод шүү дээ. Нэг ажлын хэсэг байгуулна. Тэгээд л протокол уншихад ядаж миний энэ үгийг уншаасай билээ гэдэг дараачийн тэр гишүүдэд бас би зориуд хэлж байгаа юм.

**Н.Энхболд:** Баярлалаа. Тэгэхээр уг нь бид нар нэгэнт л Үндэсний зөвлөлөө байгуулаад өгчихсөн бол үүнээс цааших асуудал нь тэндээ л явж байх ёстой л доо. Даанч тэгж явж чадаагүй байхгүй юу. Сүүлийн 2 жил ийм асуудал удаа дараа гаргаад дотроос нь, хамт олноос нь, удирдлагаас нь, Үндэсний зөвлөлийн гишүүдээс нь удаа дараа асуудал ирж байсан учраас нэгд.

Хоёрдугаарт, энэ байгууллага тодорхой хэмжээгээр улсын төсвөөс санхүүждэг учраас хоёрт.

Гуравдугаарт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль гэж гарсан учраас.

Дөрөвдүгээрт, энэ байгууллагыг Их Хурлын зүгээс хариуцаж байх байгууллага нь Байнгын хороо учраас энэ асуудлуудыг хэлэлцэж байгаа юм. Ийм олон шалтгаануудын үүднээс. Түүнээс Сүхбаатар гишүүний ярьж байгаа үнэн. Бид нар Үндэсний зөвлөлөө л зөв байгуулаад өгчихсөн байхад үүнээс цааших нь тэнд явах ёстой. Цалин хөлстэй холбоотой, төрөөс үзүүлэх дэмжлэгтэй холбоотой, үйлчилгээний хөлстэй холбоотой асуудал бас Засгийн газраар оролцохоос өөр арга байхгүй.

Угаасаа хуульдаа тийм заалттай учраас ийм юм орж.

Тэгээд саяын гишүүдээсээ гаргасан саналыг тусгаад тэгээд тогтоолынхоо төслийг зарчмын хувьд дэмжээд баталъя. Саналаа хураая. Санал хураалт.

Хөөе энэ чинь. Мөнхцэцэг гишүүний микрофоныг өгчих дөө.

**Ц.Мөнхцэцэг:** Би дэмжиж санал өгсөн боловч сая төхөөрөмж маань гацсан учраас саяын санал хураалтыг хүчингүйд тооцож өгнө үү.

**Н.Энхболд:** Мөнхцэцэг гишүүний горимын саналаар санал хураая. Саяын санал хураалтыг хүчингүйд тооцъё. Санал хураалт.

11 гишүүнээс 6 нь дэмжиж, горим дэмжигдлээ.

Одоо саналаа эргээд түрүүчийнхээ бас ойлголцсон томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Тогтоолоо баталъя. Болчихно.

54.5 хувиар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Гишүүддээ баярлалаа, ажлын хэсгийнхэнд баярлалаа. Дараагийн асуудалдаа оръё. Бусад асуудлын хүрээнд Сүхээ.

12.59 цаг

**Бусад асуудлын хүрээнд “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Их Хурлын тогтоолын төсөл хэлэлцэнэ.**

Байнгын хорооноос боловсруулсан төсөл байгаа. Энэ төслийг боловсруулахдаа Улсын Их Хурлын удирдлага, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар холбогдох байгууллагуудтай санал солилцсоны үндсэн дээр боловсруулж та

бүхэнд танилцуулж байна. Ийм асуудал гарсан. Одоо энэ Их Хурлын гишүүдийн тоо 126 болчихсон. Ордны доторх зохион байгуулалт, гишүүдийн өрөө тасалгаа бэлдэх, танхим бэлдэх энэ бүх асуудлыг хариуцсан ажлын хэсэг гараад, Мөнхбаатар даргаар ахлуулаад ажиллаж байгаа. Энэ хугацаанд бол бид нар жижиг танхимдаа Их Хурлаа явуулж байна. Том танхимын засварын ажил ид явж байгаа.

Одоо яг 126 гишүүний ажлын байр, өрөө тасалгааны асуудал, дотоод зохион байгуулалтын асуудал үлдээд байгаа юм. Хэд хэдэн удаа ажлын хэсэг хуралдаад янз бүрийн байдлаар оролдоод тэгээд хамгийн сүүлд Их Хурлын удирдлага, Засгийн газар одоогоор хүрч байгаа ойлголт юу вэ гэхээр Тагнуулын ерөнхий газрын байранд Засгийн газрын Хэрэг эрхлэх газрыг шилжүүлэх ажлыг шат дараалалтай хийгээд, яваандаа Тагнуулын ерөнхий газар дахиад биеэ даагаад өөр барилгатай болох тухай асуудлыг зарчмын хувьд ойлголцоод юу ч гэсэн Улсын Их Хурлаас тогтоол гараад, чиг өгөөд 7 сарын дараагийн Их Хурал эхлэхэд энэ дотор ажлын байрнууд, хурлын байрнууд бүгд бэлэн байх зохион байгуулалтын арга хэмжээ авъя. Ингэхийн тулд дараах зүйлүүдийг хийе гэсэн ийм ойлголцолд хүрээд тогтоолын төсөл боловсруулсан байгаа юм. Би тогтоолын төслийг та бүхэнд уншаад танилцуулчихъя.

“Засгийн газарт өгөх чиглэл өгөх тухай” Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийг үндэслэн Монгол УИХ-аас тогтоох нь:

1.Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийн дагуу Улсын Их Хурлын нийт гишүүдийн тоо 126 болж нэмэгдсэнтэй холбогдуулан Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн үр дүнгээр байгуулагдах Улсын Их Хурлын үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөл, боломжоор хангах зайлшгүй шаардлагыг харгалзан холбогдох хууль тогтоомжийн хүрээнд дараах арга хэмжээг шуурхай

авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар Оюун-Эрдэнэ-д даалгасугай.

1.Улсын Их Хурлын хэвийн ажиллах нөхцөлийг хангах зорилгоор Засгийн газрын хэвлэх газрыг Тагнуулын ерөнхий газрын одоогийн байрлаж буй байранд шилжүүлэн байршуулах, Тагнуулын ерөнхий газрыг Хөшигийн хөндий Шинэ Зуунмод хотын бүтээн байгуулалтын хүрээнд шинээр төлөвлөгдөж буй Засгийн газрын байгууллагуудын нэгдсэн байрны цогцолборт байршуулахаар зохион байгуулах.

2.Засгийн газрын байгууллагуудын нэгдсэн байрны цогцолборын техник, эдийн засгийн үндэслэл, зураг төслийг холбогдох дэд бүтэц Их тэнгэрийн болон Номтын амны ерөнхий төлөвлөлттэй хуульд нягт уялдуулан цогц байдлаар цогц төсөл байхаар төлөвлөж, барилга угсралтын ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу Тагнуулын ерөнхий газарт хариуцуулан хэрэгжүүлэх.

3.Энэ тогтоолын 1 дэх заалтын 2-т заасан цогц төслийг улсын төсвийн эх үүсвэрээр зохих журмын дагуу гүйцэтгэхээр тооцож, эх үүсвэрийг жил бүрийн улсын төсвийн төсөлд үе шаттай тусгаж байх.

4.Цогц төслийг хэрэгжүүлэх шаардлагатай Засгийн газрын баталгаа, төрөөс үзүүлэх бодлогын бусад дэмжлэг, тусалцааг холбогдох хууль тогтоомжийн дагуу эрх бүхий байгууллагад тухай бүр нь тавьж ишидвэрлүүлж байх.

Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороо Энхболд-д даалгасугай гэсэн ийм тогтоолын төсөл байгаа юм.

Энэ нь ерөнхийдөө нөгөө шинэ Зуунмодын тийшээ Төв аймгийн

Зуунмодын хойд талын хэсэг дээр Номтын ам гэж байгаа хэсэгт Засгийн газрын байгууллагуудын бас тийм цогц байхаар төлөвлөж, яригдаж байгаа юм билээ. Энэ хүрээнд тухайлбал Тагнуулын ерөнхий газарт тэнд байх учраас энэ зураг, төсвийн асуудал бусад зүйлүүдийг нь энэ газарт нь хариуцуулахаар бодож оруулсан ийм тогтоолын төсөл байгаа юм.

Асуух саналтай гишүүд байна уу?

Сүхээ гишүүн, асуулт.

**Ж.Сүхбаатар:** Энэ Тагнуулын чинь юмыг би 13 жилийн өмнө Төрийн байгуулалтын байнгын дарга байхад чинь бас энэ парламент уг нь газрыг нь авч өгөх гээд Тагнуулынхантай харилцаж байсан юм. Одоо энэ Тусгай албан хаагчдын эмнэлгийн газрыг авах гээд, Тагнуулын газрыг авах гээд. Тэгээд Тагнуулынхан чинь надад юу гэж ярьж байсан юм гэхээр тухайн үед бид нүүж болж байна. Тэгвэл нэг дор ингээд бөөнөөрөө л тусгай хэрэгсэлтэй учраас бөөнөөрөө л нөгөө очих газраа л шууд л очихгүй бол гарах боломжгүй эд нар гээд л ингээд л ярьдаг байсан юм. Тэгээд өөр газар уг нь газар авч байсан юм. Тэгээд авах, мань мэтээс хойш яасан гэсэн чинь буцаад нөгөө эндээ шинээр барилга бариад ингээд суучихсан.

Тусгай албан хаагчдын эмнэлгийн газрыг уг нь авч яваад Зэвсэгт хүчний госпиталын тэнд уг нь тэр эмнэлгийг нь шинээр бариулчихъя гэж байсан чинь буцааж Нямдорж сайд эндээ шинээр дахиж бариулаад ингээд парламентыг хоёр талд нь ингээд газаргүй болгочихсон байхгүй юу. Уг нь тэр үед Төрийн байгуулалтын хороонууд ажиллачихсан байсан юм. Тэгэхээр одоо ингээд харахаар Тагнуул чинь ингээд Хэрэг эрхлэхийн тодорхой хэсэг ингээд аажим, дэс дараатай орно гэхээр чинь тэд нарын хэсэг чинь өөрсдөө яаж шилжиж нүүх вэ? Тэр асуудлаа ойлголцсон юм уу?

Тэгээд би санаа зовж байгаа нь Тагнуулын байгууллагын үйл ажиллагааг сулруулж байна ч гэдэг юм уу, Тагнуулын ажилтнуудын хэвийн ажиллах нөхцөлд сөрөг нөлөөлж байна гэдэг ийм юм руу орчих юм биш байгаа даа? Тэрийгээ дотоод талаас нь ойлголцсон, ярьсан, хөөрсөн. Тэгэхгүй бол Төрийн байгуулалтын байнгын хороон дээр өнөөдөр ингээд бид хэд шийдчихдэг, хэдэн Их Хурлын гишүүд нь аягүй бол сүүлдээ зарим хүн нь бид хэдийг ингээд барьж байгаад энийгээ тэгээд оруулах гээд шийдчихсэн гэх вий дээ. Тэгээд энэ дээр яаж Засгийн газартайгаа яаж ойлголцсон юм бол? Тагнуулынх нь удирдлагатай яаж ойлголцсон юм бол? Тэр нэгжийнх нь бас хүмүүс нь бас зөв ойлгоосой билээ дээ.

Тэгэхгүй бол энэ чинь зарим талаар их сонин ойлголт үүсгэнэ. Хэрэг эрхлэх газрын зарим ажилтнууд Тагнуулын байгууллага дээр зэрэг хэсэг хугацаанд ажил явах гэж байгаа ч юм шиг. Гэтэл яг Тагнуулын байгууллагын шилжиж очих байр миний мэдэж байгаагаар байхгүй байхгүй юу. Тэр чинь тусгай тоноглолтой. Тэгэхээр чинь энэ байдлуудыг эд нар их зөв яахгүй бол их тийм сонсогдоход сая их сонин сонсогдоод байна л даа.

**Н.Энхболд:** Одоо ингээд шууд мэдээж Тагнуулын ерөнхий газраас эндээсээ гараад явчих бололцоо байхгүй л дээ. Бид нар тооцоо хийж үзээд энэ дотор бас нэлээн байр сав суллагчихсан байгаа юм. Тийм одоо бас 30-40-өөд өрөө, 30 орчим өрөө суллах шаардлага байгаа энд. Тэр хэмжээний Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын ажилтнууд тэр хэмжээний ажилтнууд одоогоор Тагнуулын ерөнхий газрын байрлаж байгаа байшингийн тодорхой хэсэгт ажиллах боломж нь байгаа юм байна лээ. Тэгээд шат дараатайгаар ингээд зураг, төсөв юмнуудаа хийгээд, төсөв тооцоогоо хийгээд явах.

Мэдээж энэ өнөө маргаашдаа хий бичих ажил биш. Гэхдээ хамгийн түрүүн

шийдэх асуудал нь бол дараагийн Их Хурал эхлэхэд бүх гишүүд байртай, тийм ингээд байж байгаа учраас. Тэгээд дараагийнхаа тэр газрын асуудал ерөнхийдөө Тагнуулын ерөнхий газар үйл ажиллагаагаа хуульд заасан шаардлагын хэмжээнд ажиллах боломжтой гэдгийг нь Тагнуулын ерөнхий газрын удирдлагатай Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Их Хурлын удирдлага яриад ойлголцсон юм байна лээ. Тэгээд ийм тогтоол оруулж байгаа юм гэдгийг хэлье.

Тогтоолыг дэмжээд чуулганы нэгдсэн хуралдаанд оруулчихъя гэсэн санал хураалт явууллаа. Санал хураалт.

11 гишүүнээс 6 дэмжиж, 54.5 хувиар санал дэмжигдлээ.

Пүрэвдорж гишүүн сая дараад байх шиг байсан эсрэг гарчихсан байх чинь. Орох уу?

7 гишүүн дэмжиж, асуудлаа хэлэлцэж дууслаа.

Санал, дүгнэлтийг би өөрөө танилцуулъя. Дараагийн асуудалдаа оръё.

14.08 цаг

**Улс төрийн намын тухай хуулийн хэрэгжилтийн талаарх холбогдох байгууллагуудын мэдээг сонсьё.**

Уригдаж ирсэн хүмүүсийг оруулъя. Ажлын хэсэг. Өнөөдрийн энэ мэдээлэл сонсоход Сонгуулийн ерөнхий хорооны дарга Дэлгэрнаран, Ерөнхий аудиторын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Загджав, Улсын дээд шүүхийн Тамгын газрын дарга Заяадэлгэр, Заяадэлгэр дарга байна уу? Аудитын газрын Санхүү-Нийцлийн газрын захирал Наранчимэг? Загджав дарга ирчихсэн байгаа тийм ээ. Сонгуулийн ерөнхий газрын Тамгын газар Бат-Эрдэнэ, Сангийн яамны Нягтлан

бодох бүртгэлийн бодлогын газрын дарга Болормаа? Байна. Үндэсний статистикийн хорооны Нийгмийн статистикийн газрын дарга Оюунцэцэг, Дээд шүүхийн Тамгын газрын Улс төрийн намын бүртгэлийн албаны дарга Батсүх, Жендерийн үндэсний хорооны нарийн бичгийн дарга ажлын албаны дарга Энхбаяр? Энхбаяр дарга тэр байна. Сонгуулийн ерөнхий хорооны гишүүн Улс төрийн намын мэдээлэл арга зүйн газрын дарга Баяндүүрэн дарга байна. Мөн хорооны Улс төрийн намын санхүүжилт, хяналтын газрын дарга Булгамаа, Жендерийн үндэсний хорооны Нийгмийн түншлэл, хамтын ажиллагаа хариуцсан мэргэжилтэн Чанцал ийм хүмүүс орж байна.

Өнөөдрийн ямар шалтгаанаар энэ мэдээлэл авах гэж байгаа юм бэ гэхээр Их Хурал 23 оны 7 сарын 7-нд Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг цоо шинэ үзэл баримтлалын хүрээнд баталсан.

Ер нь 5 оны Улс төрийн намын тухай хууль бол үзэл баримтлал нь нэлээн хуучирсан, улс төр, нийгэм, эрх зүйн шаардлага нь их өөр болсон байгаа. 8 оноос хойш үе үеийн Улс төрийн намын тухай хуулийг шинэчлэх асуудлыг ярьж байсан боловч энэ талаар өөрчлөлт орж чадаагүй байсан.

Харин 19 онд Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсны хүрээнд 19.1 дүгээр зүйл дээр анх удаа улс төрийн намыг дотоод ардчилалтай байх, намын хөрөнгө, орлогын эх үүсвэр, зарцуулалт нийтэд ил тод байх, төрөөс санхүүгийн дэмжлэг олгох, төрийн санхүүжилт олгох нөхцөлийг хуулиар тогтооно гэсэн заалт баталсан. Ийм учир бас энэ нь өөрөө Улс төрийн намын тухай хуулийг зайлшгүй шинэчилж батлахаас өөр аргагүй ийм батлах үндэслэл нь болсон.

Тэгэхээр энэ хуульд бол Дээд шүүх намыг бүртгэх, Сонгуулийн ерөнхий хороо санхүүжилт, мэдээлэл арга зүйн дэмжлэг үзүүлэх, Сангийн яам

санхүүжилт олгох, Жендерийн үндэсний хороо жендерийн тайлан авах үүрэг хүлээсэн байгаа. Энэ дээрх төрийн байгууллагууд цугласан мэдээллүүдэд мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх, улмаар намын статистикийг хөгжүүлэхэд Үндэсний статистикийн хороо оролцох боломж, үүрэгтэй. Улс төрийн намын статистик бол мэдээлэл, арга, судалгаа шинжилгээний болон төрийн байгууллагын үйл ажиллагааг холбож өгөх өндөр ач холбогдолтой ийм заалт байсан.

Тийм учраас Их Хурлын тухай хууль батлах, хуулийн хэрэгжилтийг хангах онцгой бүр төрийн эрхийн хүрээнд Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгын хэрэгжилтийг хангах үүднээс дээрх байгууллагуудад одоо яг юу хийж байгаа талаар мэдээлэл сонсох ажил чухал байгаа. Ер нь хууль өөрөө 7 сарын 1-нээс эхлээд хэрэгжиж эхэлнэ.

Тийм учраас та бүхнээс товчхон товчхон зөвхөн мэдээлэл авах зорилгоос болж байгаа юм. Жишээ нь, Дээд шүүхээс нам бүртгүүлэх шийдвэртэй холбоотой мэдээллийг бүртгэж энэ тухай нийтэд мэдээлж, Сонгуулийн ерөнхий хороонд хүргүүлж байх заалтын дагуу одоогоор юу хийгдээд байна, цаашид юу анхаарах ёстой вэ? Сонгуулийн ерөнхий хорооноос нэлээд олон үүрэгтэй бүртгэж авах, жендерийн дүгнэлтийг хүлээж авах, санхүү үйл ажиллагааны тайланг нь авах, ил тод мэдээлэх гэх мэтчилэн холбогдох журмуудыг батлах ийм үүрэгтэй.

Сангийн яамнаас төрөөс санхүүгийн дэмжлэгийг хуваарилах журам баталж мөрдүүлэх үүрэгтэй. Үндэсний Аудитын газар бол намд төрийн санхүүжилт олгох, төрөөс үзүүлэх шууд бус дэмжлэгийг шийдвэрлэх, намын санхүүгийн тайлан үйл ажиллагааны товч тайланг хянаж, дүгнэж байх. Дүгнэлт гаргаж байх, тайлагнаж байх, нийтэд мэдээлж байх, намын баримт бичиг, мэдээллийн цахим

хуудсанд байршуулах, шинэчлэх, хариуцлага тооцохтой холбоотой журмуудыг гаргах ёстой.

Жендерийн үндэсний хороо намууд жендерийн эрх тэгш байдлыг хангасан эсэх талаар дүгнэлтийг хүлээж авч байх. Харилцаа холбооны зах энэ нь яах вэ өнөөдөртөө орохгүй. Үндэсний статистикийн байгууллагууд хуулийн хэрэгжилтийг хангахад дэмжлэг үзүүлж, улс төрийн намын статистикийг хөгжүүлэх ийм үүргийг хуулиар хүлээсэн байгаа.

Тэгэхээр одоо энэ ингээд шууд Дэлгэрнараран дарга намуудын хуультай холбоотой танайд ноогдсон үүргийн хэрэгжилт ямархуу байгаа вэ? Цаашид юу анхаарах вэ? Товчхон товчхон хэлээд явчихъя 4 номерын микрофон.

**П.Дэлгэрнараран:** 2019 онд Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2023 оны 7 сарын 7-нд баталсан. Уг хуульд зааснаар Сонгуулийн ерөнхий хороо нь улс төрийн намын санхүүжилт, түүнд тавих хяналтын болон.../минут дуусав./

**Н.Энхболд:** Тэр юмнуудаа яах вэ. Яг тэр хуулийнхаа заалтыг хэлээд л ард нь ийм юм хийчхээд байна, дараа нь ингэмээр байна гээд л яриад явчихдаг. Дэлгэрэнгүй тайлангууд хэрэггүй. Бид нар хуулиа бүгд мэдэж байгаа, хэн ямар үүрэгтэйг мэдэж байгаа.

**П.Дэлгэрнараран:** Тэгээд бид нар бол Улс төрийн намын тухай хууль, тэгвэл би заалтаар нь хэлээд дараа нь хийж байгаа ажил. Улс төрийн намын тухай хуулийн дагуу Сонгуулийн ерөнхий хороон дээр дээр дурдсан чиг үүрэг бүхий уг хуулийг хэрэгжүүлэх ажлыг хариуцсан бүтцийн нэгжийг бий болгож, Тамгын газар дотор улс төрийн намын санхүүжилт, мониторингийн газар, Улс төрийн намын мэдээлэл арга зүйн газар

гэсэн 2 бүтцийн нэгжийг бий болгож, уг ажлыг хариуцуулан ажиллаж байна.

Шинэ тутам байгуулагдсан бүтцийн нэгж, түүнд албан хаагчдыг мэргэшүүлэх чадавхжуулах зорилгоор Нэгдсэн Үндэстний байгууллагын хөгжлийн хөтөлбөр, Улсын дээд шүүх, Сангийн яам, Үндэстний аудитын газар болон иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран албан хаагчдыг чадавхжуулах ажлыг хийж байгаа.

Гуравдугаарт нь Улс төрийн намын хуулийн хэрэгжилтийг бүрэн хангах зорилгоор Улсын дээд шүүхэд бүртгэлтэй улс төрийн намуудтай шууд харилцах, мэдээлэл шуурхай солилцох ажилтныг нам тус бүрээр томилуулан хамтран ажиллаж байгаа.

Дараа нь Улс төрийн намын тухай хуулийн онцлог, зохицуулалтуудын талаар иргэд, хэвлэл мэдээллийн байгууллага, намын бүх шатны байгууллагад мэдээлэл өгөх уулзалт, сургалтыг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөр, Улсын Их Хурлын Тамгын газар, иргэний нийгмийн байгууллагуудтай хамтарч, 2023 оноос хойш бүх орон нутгийн бүх засаг захиргааны нэгжүүдэд явж сургалтыг хийсэн байгаа.

Хуулийн үзэл баримтлал хэрэгжүүлэхэд анхаарах асуудлаар Улсын дээд шүүхэд бүртгэлтэй 37 намын удирдлага холбогдох албан тушаалтанд мэдээлэл өгөх уулзалт сургалтыг 4 удаа бид нар зохион байгуулж, харилцан хамтран ажиллах арга хэлбэрүүдээ тогтсон.

Дараа нь Улсын дээд шүүхтэй хамтран Улс төрийн намын тухай хуулийг онцлог зохицуулалт, анхаарах асуудал, хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд заасан хугацаа зохион байгуулалтын талаар мэдээлэл өгөх уулзалтыг мөн Улсын дээд шүүхтэй хамтарч зохион байгуулсан.

Хуульд заасан журам, мэдээллийн ил тод байдлыг хангах талаар би дараах асуудал ажлуудыг хийж байгааг илтгэе.

Улс төрийн намын тухай хуульд нийцүүлэн улс төрийн намын бүртгэл хөтлөх журмын төсөл Сонгуулийн ерөнхий хорооны зүгээс саналаа хүргүүлсэн бөгөөд Улсын дээд шүүхийн нийт гишүүдийн хуралдааны 2024 оны 2 сарын 23-ны өдрийн 6 дугаар тогтоолоор уг журам батлагдсан. Улс төрийн намын тухай хуульд зааснаар намын санхүүжилтийн тайлангийн бүтэц, агуулга, хөрөнгө, орлого, зарлагын ангиллын тодорхойлон тайлагнах журмыг Сонгуулийн ерөнхий хороо нь Сангийн яамтай хамтран батална.

Хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд заасан хугацаатай уялдуулан энэхүү журмын төслийг боловсруулсан бөгөөд улс төрийн нам, иргэний нийгмийн байгууллагуудаас нээлттэй санал авах ажиллагааг зохион байгуулж байна.

Гуравдугаарт нь хуулийн хэрэгжилтийг бүрэн хангах зорилгоор Сонгуулийн ерөнхий хорооны цахим хуудаст намын нээлттэй мэдээлэл цэс шинээр үүсгэж, энэхүү цэсэд улс төрийн намын 16 төрлийн мэдээллийг нээлттэй байршуулах гэсэн ажлыг зохион байгуулсан.

Дөрөвдүгээрт нь Улс төрийн намын тухай хуулийн зохицуулалтын талаар Улс төрийн намын хуулийн хэрэглээ гарын авлагыг Нэгдэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран боловсруулж, хуулийг Монгол, Англи хэлээр хэвлүүлээд намуудад болон шаардлагатай бусад байгууллагуудад хүргүүлэн мэдээлэл гарын авлагаар ханган ажиллаж байна.

Тавдугаарт нь намын санхүүгийн тайлангийн ил тод байдлыг хангах,



цахим хэлбэрт шилжүүлэх, хүлээн авах, тайлагнах үйл ажиллагааг ил тод, хүндрэлгүй зохион байгуулах зорилгоор программ хөгжүүлэх ажлыг зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна. Энэ программын хөгжүүлэлт, үүний санхүүжилтийн асуудлаар бол бид нар олон улсын байгууллагуудтай ярьж тохироод байгаа.

Цаашид Улс төрийн намын тухай хуулийн хэрэгжилтийг бүрэн хангах, хуулийн үзэл баримтлал, шинэ онцлог зохицуулалтуудын талаар иргэд болон холбогдох байгууллагууд мэдээлэл өгөх, мэдээллийг өргөн хүрээнд тогтмол өгөх ажлыг зохион байгуулан ажиллах шаардлагатай гэж үзэж байна. Баярлалаа.

**Н.Энхболд:** Баярлалаа. Дээд шүүхийн Тамгын газрын дарга Заяадэлгэр дарга товчхон. Танайх ч журмаа гаргачихсан юм байна лээ дээ тээ? 1 номерын микрофон. 2 номер дээрээс ярьчих.

**С.Заяадэлгэр:** Улс төрийн намын тухай хууль шинэчлэн батлагдсантай холбоотойгоор Монгол Улсын дээд шүүхээс улс төрийн намын бүртгэлийн журмыг 2 дугаар сард баталж мэдээлсэн байгаа.

Мөн хуульд заасны дагуу улс төрийн намын бүртгэл хөтлөх, бүтцийн нэгжийг байгуулж үйл ажиллагаандаа ороод байна. Өнөөдрийн байдлаар Монгол Улсын дээд шүүхэд шинэ нам үүсгэн байгуулах 3 өргөдөл, намын даргын өөрчлөлтийн бүртгэлүүд 5 өргөдөл, мөн намын дүрмийн өөрчлөлтийн 7 өргөдөл ирсэн. Эдгээрийг бүрэн дүүрэн шийдвэрлэн ажиллаж байна.

Шүүхийн тухай хуулиар улс төрийн намын бүртгэлийг хөтлөх хүрээ хязгаарыг өөрчлөхдөө улс төрийн намыг бүртгэх, бүртгэхээс татгалзах, идэвхгүй болгох идэвхгүй болон идэвхтэйд тооцох, татан буулгах, тамга тэмдгийн хяналт,

регистр, хувийн дугаараар гэрчилгээ олголт, хүчингүй болголт, эдгээртэй холбоотой бүртгэл гэж тодорхой зааж өгсөнтэй холбоотойгоор мэдээллийн санг шинэчлэх ажил хийгдсэн.

Монгол Улсын дээд шүүхэд өнөөдрийн байдлаар 37 улс төрийн нам бүртгэлтэй байна. Энэ мэдээллийг бид хуульд заасан чиг үүргийн дагуу шинэчлээд мөн Сонгуулийн ерөнхий хороо Улсын бүртгэлийн байгууллагатай мэдээлэл солилцон хамтран ажиллаж байна. Хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд нийт улс төрийн намуудад хэлэлцүүлэг зохион байгуулж, энэ намын өөрчлөлт, онцлог, Монгол Улсын дээд шүүхээс баталсан улс төрийн намын бүртгэлийн журмыг танилцуулах үйл ажиллагааг Сонгуулийн ерөнхий хороо, Улсын бүртгэлийн газартай хамтран зохион байгуулаад байна. Өнөөдөр Улс төрийн намын тухай хуулийн 14.10-аар зарим нэг намуудын нам бүртгүүлэх өргөдөл, сонгууль болохоос өмнө 90 хоногийн хугацаанд түдгэлзэх ёстой. Энэ дагуу түдгэлзсэн 2 намын бүртгэл байгаа. Бусад асуудлууд хугацаандаа шийдвэрлэгдээд явж байгаа.

Цаашид бид бүхэнд тулгамдаж байгаа асуудал бол Улсын бүртгэлийн байгууллага Сонгуулийн ерөнхий хороотой хамтран улс төрийн намын бүртгэлийн цахим системийг хөгжүүлэх, энэ төрийн байгууллага хооронд мэдээллийг шуурхай солилцох, ер нь энэ бүртгэлтэй холбоотой болон бусад процедурыг бид нар хөнгөвчлөх, хялбар болгох, ээлтэй болох намуудад иргэдэд нээлттэй болох энэ чиглэлийн өөрчлөлтүүдийг хийх шаардлагатай тулгамдсан асуудлын хүрээнд бид нар бас тодорхой бэлтгэлийг хангаад судалгааг хийгээд, тодорхой төсөв санхүүжилтийг бас ирэх жилийн төсвүүдэд тусгаад энэ системийн хөгжүүлэлт дээр ажил төлөвлөж байгаа.

**Н.Энхболд:** Баярлалаа. Аудит Самбууням дарга. 5 номер.

**Я.Самбууням:** Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Үндэсний аудитын газраас Самбууням байна.

Улс төрийн намын тухай хууль шинэчлэн батлагдсантай холбогдуулаад хуулийн 31, 39 дүгээр зүйлд төрийн аудитын байгууллагын оролцооны хэлбэр, хугацаа, шалгуур, сонгуулийн байгууллагад улс төрийн намуудтай харилцах харьцааны талаар нарийвчилсан зохицуулалт орж ирсэн байгаа. Өмнө буюу 2005 онд батлагдсан Улс төрийн нам намын тухай хуульд төрийн аудитын байгууллагаас хэрэгжүүлэх чиг үүргийн талаар тодорхой заалт байхгүй байсан. Шинэчилсэн хуулийн хүрээнд бол дараах ажлыг хэрэгжүүлэхээр чиг үүрэг заагдсан. Үүний хүрээнд бол бид ажлаа төлөвлөн бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

Сонгуулийн төв байгууллагын 2025 оны төсвийн төслийг хянахад улс төрийн намд олгох санхүүжилтийг сонгогчийн тоо, хөдөлмөр хөлсний доод хэмжээ, намуудын тоо зэрэг үндэслэж, үнэн зөв төлөвлөсөн эсэхийг нь хянахаар төлөвлөж байна. Мөн намд төрийн санхүүжилт олгох, төрөөс үзүүлэх шууд бус дэмжлэгийг шийдвэрлэх намын санхүүгийн тайлан болон үйл ажиллагааны товч тайланг хянах, дүгнэлт гаргах, тайлагнах, нийтэд мэдээлэх, намын баримт бичиг, мэдээллийг цахим хуудсанд байршуулах, шинэчлэх, хариуцлага тооцохтой холбоотой журамд санал өгөх талаар судалж ажиллаж байна. Намуудад олгох санхүүжилт, түүний зарцуулалт, тайлагналд Төсвийн тухай хуулийн 8.9.6-д заасны дагуу 2025 оны 4 дүгээр сард бол тайланд хяналтыг хэрэгжүүлнэ. Эндээ бол төсвийн ерөнхийлөн захирагч буюу Сонгуулийн ерөнхий хорооны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийхээр төлөвлөж байна.

Мөн намуудад олгосон санхүүжилт, төсвийн гүйцэтгэлд өгсөн

дүгнэлтийг Төсвийн тухай хуулийн 8.10.2-т заасны дагуу 2025 онд бол Монгол Улсын Засгийн газрын нэгдсэн тайлан, нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн хүрээнд нь Улсын Их Хурал тайлагнахаар төлөвлөж ажиллаж байна.

Мөн бид Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль өөрчлөгдсөнтэй холбогдуулаад сонгуулийн хуульд заагдсан зарим чиг үүргийг бол хэрэгжүүлээд ажиллаж байна. Хуулийн 50.1-д заагдсаны дагуу улс төрийн нам, эвслийн сонгуулийн зарцуулах зардлын дээд хэмжээг батлах аргачлалыг, саналыг боловсруулаад Сонгуулийн ерөнхий хороонд хүргүүлсэн. Энэ аргачлалын дагуу тооцсон зардлын дээд хэмжээг бол 2024 оны 2 сарын 29-ний өдөр Сонгуулийн ерөнхий хороонд хүргүүлсэн. Мөн хуулийн 38.7-д заагдсаны дагуу ээлжит сонгуульд оролцох 27 нам, 2 эвслийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргаад байна.

Хуулийн 38.10-д заагдсаны дагуу улс төрийн 2 намд 162 иргэн, 3 хуулийн этгээдээс өгсөн 157.3 сая төгрөгийн сонгуулийн хандивыг аудиталж дүгнэлтийг мөн Сонгуулийн ерөнхий хороонд хүргүүлж ажиллаад байна.

Хуулийн хүрээнд бол бид дараах ажлуудыг хийхээр бэлтгэл ажлыг хангаад төлөвлөөд явж байна. Энд бол бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөр, хандивын тайланд дүгнэлт гаргах, хуулийн 58.1-д заагдсаны дагуу Улсын Их Хурлын сонгуульд оролцох нам, эвсэл, гишүүдийн зардлын тайланг хянаж, олон нийтэд мэдээлэх.

Гуравдугаарт, Хуулийн 10.9 дүгээр заалт зүйлд заагдсаны дагуу сонгууль зохион байгуулахтай холбогдуулсан улсын төсвөөс олгосон санхүүжилтэд аудит хийхээр төлөвлөөд ажиллаж байна.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

**Н.Энхболд:** Баярлалаа. Сангийн яам, Нягтлан бодох бүртгэлийн бодлогын газрын дарга Болормаа, 7 номерын микрофон.

**Б.Болормаа:** Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгын 36 дугаар зүйлийн 36.6-д заасан санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, намын санхүүгийн тайлангийн бүтэц, агуулга, хөрөнгө орлого, зарлагын ангиллын тодорхойлон тайлагнах журмыг сонгуулийн төв байгууллагатай хамтран хуульд нийцүүлэн батална гэж заасны дагуу манай яамнаас хийсэн ажлыг товч танилцуулъя.

Яг энэ хуулийн заалтын дагуу бид нар Улс төрийн намын нягтлан бодох бүртгэлийн журмын төслийг боловсруулаад Сонгуулийн ерөнхий хорооноос санал авахаар 4 дүгээр сарын 19-ний өдөр хүргүүлсэн байгаа.

Одоогийн байгаа энэ төслөөр улс төрийн нам нь олон улсын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцсэн санхүүгийн тайлан тодруулгын маягтыг бэлтгэнэ. Тэгээд санхүүгийн тайлангийн маягт болон дансны нэгдсэн жагсаалтыг нь бас тус яамнаас төслийг нь боловсруулж гаргасан байгаа.

Сонгуулийн ерөнхий хороотой хамтраад манайх энэ журмыг улс төрийн намуудын оролцоотойгоор мөн нийтэд хэлэлцүүлэг хийнэ. Тэрний дараагаар санхүүгийн тайлангийн E-Balance цахим систем дээр бид нар энэ санхүүгийн тайлан, одоо энэ журмын төсөл батлагдах юм бол жилийн эцсийн санхүүгийн тайланг хүлээж авахтай холбогдуулаад E-Balance цахим систем дээр бүх бэлтгэл ажлыг хийхээр ингэж ажиллаж байна. Товчхондоо ийм байна. Баярлалаа.

**Н.Энхболд:** Баярлалаа. Жендерийн үндэсний хорооны нарийн бичгийн дарга ажлын албаны дарга Энхбаяр, 6 номер.

**Т.Энхбаяр:** Байнгын хорооны дарга болон гишүүдэд энэ өдрийн мэндийг хүргэе.

Улс төрийн намын тухай хуулийн 8.7, 8.8-д заасны дагуу Жендерийн үндэсний хороо тайлан хүлээн авах болоод тайлан Сонгуулийн ерөнхий хороонд ирэх оны 8 сарын 1-ний дотор хүргүүлэхээр байгаа. Энэ бэлтгэл ажлын хүрээнд юуны өмнө намаас авах тайлангийн маягтыг Үндэсний статистикийн хороогоор батлуулах энэ ажлыг яг одоо хийгдээд явж байгаа. Энэ хүрээнд нэгдүгээрт нь улс төрийн намын бүх шатын байгууллагын хүйсийн тэнцвэрт байдлын тайлан мэдээ 1 дүгээр маягт, аймаг, нийслэл, улс төрийн намын хүйсийн тэнцвэрт байдлын мэдээ бүртгэлийн маягт 2, сум, дүүргийн улс төрийн намын байгууллагын хүйсийн тэнцвэрт байдлын бүртгэлийн маягт 4, 3, улс төрийн намаас нэр дэвшигчийн сонгуулийн сурталчилгааны дэмжлэг үзүүлсэн тайлан гэсэн ийм 4 агуулгын хүрээнд 5-6 маягтыг зураад эхний байдлаар Үндэсний статистикийн хороотой зөвшилцөөд ажиллаж байгаа. 5 сардаа ерөнхийдөө маягтуудыг батлуулах, мөн маягт батлагдсаны дараагаар энэ ондоо намуудтай хамтарч ажиллаж, маягтад заасан мэдээллүүдийг ирүүлэх чиглэлд чадавч бэхжүүлэх сургалтуудыг үе шаттай зохион байгуулах ажлуудыг хийж байна.

Хоёрдугаарт нь болохоор энэ ирэх оны 8 сарын 1-ний дотор Сонгуулийн ерөнхий хорооны тайланг дүгнэлт байдлаар хүргэх гэдэг хуулийн заалт байгаа. Тэгэхээр тайлангийн маягтын дагуу бид нар 3 сарын 31-ний дотор намуудаас эрх бүхий байгууллагын эрх бүхий гишүүн нь ба намын эрх бүхий гишүүн баталгаажуулснаар тайланг авна гэж байгаа.

Гэхдээ одоо бас бид нарын ярилцах асуудал нь юу байгаа вэ гэхээр дүгнэлт өөрөө ямар хэлбэрээр Сонгуулийн ерөнхий хороонд хүргэгдэх

юм бэ гэдэг нь хуульд зөвхөн дүгнэлт хүргэгдэнэ гэж байгаа юм. Тэгэхээр маягтаар авсан тайланг бол бид нар бичгийн хэлбэрт оруулаад дүгнэлт хийх хэлбэр нь тэр нь. Тэгэхээр хэлбэрийнхээ хувьд тодорхой формат заах юм уу, үсэг, өгүүлбэрийн тоо заах юм уу, ямар хэлбэртэй байх юм гэдэг удирдамж, чиглэл одоогоор байхгүй байгаа. Тийм юм байх юм болов уу гэдгийг ажлын хэсгийн хурал дээр бас асуугаарай гэдэг ийм манай шинжээчдийн бүлгээс бас бид нар энэ асуудлаар зөвлөлдсөн. Бэлтгэл ажлыг ингээд хангаад ажиллаж байна. Баярлалаа.

**Н.Энхболд:** Оюунцэцэг дарга Үндэсний статистикийн хороо Нийгмийн статистикийн газрын дарга, 1 номер микрофон.

**М.Оюунцэцэг:** Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Үндэсний статистикийн хорооноос Улс төрийн намын тухай шинэчилсэн хуулийн хүрээнд статистикийн мэдээллийг бий болгох хүрээнд өнгөрсөн хугацаанд ямар ажил хийсэн талаар товч мэдээлэл хүргэе.

23 онд Үндэсний статистикийн хороо 4 аймагт намын дунд болон анхан шатын байгууллагын төлөөлөл, аймгийн иргэдийн хурлын ажилтнуудтай уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгуулсан. Тухайн хэлэлцүүлгээрээ улс төрийн намын мэдээлэл бий болгох хэрэгцээ шаардлагын талаар мэдээлэл солилцож, санал солилцсон байгаа.

Мөн Улсын дээд шүүхэд бүртгэлтэй улс төрийн намын дээд байгууллагуудын төлөөлөл, Жендерийн үндэсний хороо, Улсын дээд шүүх Сонгуулийн ерөнхий хороо, мөн шинжээчид болон төрийн бус байгууллагуудыг оролцуулсан уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгуулсан байгаа. Тухайн хэлэлцүүлгийн хүрээнд мөн тухайн улс төрийн намын мэдээллийг бий болгох хэрэгцээ, шаардлагын талаар мэдээлэл өгч, санал солилцсон байгаа.

Эдгээр хэлэлцүүлгийнхээ үр дүнд Үндэсний статистикийн хороо энэ Улс төрийн намын тухай хуулийн хүрээнд эрх, үүрэг бүхий намуудаас тайлан, мэдээ авах байгууллагууд болох Жендерийн үндэсний хороо, Сонгуулийн ерөнхий хороо, Улсын дээд шүүхийн төлөөллүүдийг урьж оролцуулан улс төрийн намын статистик мэдээлэл цуглуулах маягтын төслийн талаар хэлэлцүүлж, маягтын төслийг тухайн байгууллагуудад танилцуулсан байгаа.

Энэ ажлын хүрээнд эргээд Үндэсний статистикийн хороотой Жендерийн үндэсний хороо холбогдон энэ түрүүн Энхбаяр даргын хэлсэн Улс төрийн намын бүх шатын байгууллагын хүйсийн тэнцвэрт байдлын мэдээ болон улс төрийн намын нэр дэвшигчийн сонгуулийн сурталчилгаанд дэмжлэг үзүүлсэн тайлангийн ийм 2 багц мэдээллийг бий болгох хүрээнд хамтран ажиллаж байна. Нийт 3 удаагийн уулзалт зохион байгуулж, заавар зөвлөмж өгч ажиллаж байгаа.

Цаашидаа хэрэгжүүлэх шаардлагатай ажил гэвэл Сонгуулийн ерөнхий хороо болон Улсын дээд шүүхийн төлөөллүүдтэй дахин уулзаж, улс төрийн намын хандивын болон бүртгэлийн статистик мэдээллийг бий болгох хүрээнд хамтран ажиллах шаардлага байгаа.

Баярлалаа.

**Н.Энхболд:** Бүх байгууллагуудаасаа бас товч тайлангууд өгч, ерөнхийдөө 7 сарын 1-нээс хэрэгжих Улс төрийн намын тухай хуульд заасан үүргээдээ хугацаанд нь хэрэгжүүлээд явж байгаа юм байна гэж ойлгогдож байна. Тэр юун дээр Жендерийн Энхбаяр даргын танилцуулснаар тайлан ямархуу хэлбэртэй байх вэ гэдэг дээрээ бас чиглэл гаргах ёстой юм шиг байна тийм ээ? 6 номер.

**Т.Энхбаяр:** Тайлангаа болохоор нөгөө маягтаар авчихъя. Тэгээд маягтаар ирсэн тайланг бид нар нөгөө үгэн хэлбэрт оруулж өгөх байх л даа. Тэгэхээр тэр нь урт, богино аягүй их хэмжээ, дамжаа нь ямар байх юм яг дүгнэлт гэдгээ бид нар яаж тодорхойлох юм бэ гэдэг нь эрх зүйн хувьд аягүй тодорхойгүй. Тэгэхээр энэ дээрээ бас бид нар тийм чиглэл байх юм уу, удирдамж байх юм уу л гэж л харилцаад байгаа юм. Ер нь шинжээчдийн бүлэг бас энэ асуудлаар яг ажиллаж байгаа ажлын албаныхан.

**Н.Энхболд:** Хуульд яг тодорхой заагаагүй болохоор бид нар эндээс яг тийм, ийм хэлбэртэй байна гэж хэлэхэд төвөгтэй л дөө. Ерөнхийдөө тоогоор ирсэн мэдээнүүдээ товчхондоо өөрсдөө дүгнэлтээ хийгээд л эндээс ийм дүгнэлт харагдаж байна гээд л тоон мэдээтэйгээ хамт явуулчихад болох байлгүй дээ гэж бодож байна.

**Т.Энхбаяр:** Ойлголоо.

**Н.Энхболд:** Энэ танилцуулгуудтай холбогдоод асуух гишүүд байна уу?

Алга байна. Санал хэлэх гишүүн байна уу?

Мөнхцэцэг гишүүн асууя гэж байна уучлаарай.

**Ц.Мөнхцэцэг:** Тэгэхээр Улс төрийн намын тухай хууль яг Монголын ардчиллын асар том механизм бүхий ийм хууль байгаа. Улс төрийн авлигалыг бууруулах, дотоод ажлыг хангах, улс орны хөгжлийн бодлого боловсруулах гол институт намуудыг олон улсын стандартын дагуу хөгжүүлэх энэ том шинэчлэлийг бид нар хийсэн. Тэгээд энэ хуулийн маань хэрэгжилт яг энэ жилүүд, энэ цаг үед явагдаж байх ёстой. Тэгээд манай энэ Улс төрийн намын тухай хуулийн гол хэрэгжилтийг хангах төрийн байгууллагуудын үйл ажиллагаа бэлтгэл

тодорхой хэмжээнд явагдаж байна. Тэгээд 2, 3 асуулт байгаа.

Нэгдүгээрт нь Улс төрийн намын тухай хуулийн дагуу бүх намууд дотоод мэдээлэл, бүтэц, үйл ажиллагаа, санхүүжилт, санхүүжилтийн аудит гэх мэтийн энэ мэдээллүүдийгээ цахим хуудсанд нээлттэй ил тод байршуулах шаардлагатай байгаа.

Тэгэхээр энэ хугацаанд манай энэ Дээд шүүхэд бүртгэлтэй 37 намаас хэдэн нам нь яг цахим хуудсаа шинэчилж, тодорхой мэдээллийг байршуулаад байгаа вэ? Бид нар, би жишээлбэл, Монгол ардын намын гишүүний хувьд ингээд Монгол ардын намын [pat.mn](http://pat.mn) энэ хуудас руу ороход бол бүх мэдээллүүд нь байгаа. Жишээлбэл, энэ 2023 оны намын санхүүгийн тайландаа аудит хийлгээд хараат бус байгууллагаар тавьчихсан байгаа. Тэгвэл бусад намуудын хувьд энэ цахим хуудас, түүн дээр тавих мэдээллүүдээ хэр шинэчилж энэ шаардлагыг хангаж байна гэдгийг Сонгуулийн ерөнхий хорооноос асууя.

Хоёрдугаарт нь энэ Намын тухай хуулийн бас нэг чухал үүрэг бол энэ нийгмийн төлөөллийг тэгш хангах, эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, залуучуудын төлөөллийг дэмжих, тэр дотор өмнөх жилүүдэд хэрэгжиж чадаагүй байсан жендерийн тэгш байдлыг хангах асуудлыг намуудад үүрэг болгон хуульчилсан байгаа. Намууд одоо нэр дэвшигч нарынхаа 30-аас доошгүй хувийг намын дотоодын төлөөллийн болон гүйцэтгэх байгууллагууддаа 40 хувийг бол жендерийн кодыг хангах ёстой. Тэгэхээр энэ хуульдаа нийцүүлээд намууд дотоод энэ удирдлагын байгууллага дахь жендерийн кодуудаа хэр нэмэгдүүлэн шаардлага хангаж байгаа вэ? Энэ тал дээр Жендерийн үндэсний хороо маань хэр хамтран ажиллаж намуудад зөвлөмж өгч байгаа вэ гэдгийг асуумаар байна.

Дараагийн асуулт нь энэ намуудын санхүүгийн тайлан, намууд

санхүүтэйгээ холбогдуулан хатуу үүрэг хүлээж байгаа хэрэвзээ төрийн санхүүжилт болон намын хууль дахь тодорхой заалтуудыг зөрчсөн тохиолдолд намууд бол нэлээд хатуу тийм санкцууд, шийтгэл оногдуулахаар байгаа. Тэгэхээр одоо энэ намууд маань энэ намын санхүүжилтийн тайлан, намын санхүүжилт, аудит хийлгэх, хандив, үл хөдлөх хөрөнгө гээд ерөөсөө санхүүжилтийн бүх материалуудыг бэлдэж, хуулийн дагуу хэрэгжүүлэх ёстой. Тэгэхээр энэ ажил маань намуудад хэр явагдаж байна гэдэг? Мөн Сонгуулийн ерөнхий хороо болон Үндэсний Аудитын газраас асуумаар байна.

Сүүлийн асуулт нь энэ намууд дотоод ардчиллыг хангах, үүсгэн байгуулсан цагаасаа хойш нэг ч удаа хурлаа хийгээгүй, гишүүдэд тайлангаа тавьдаггүй, нэг хүний нам мэт явж ирсэн энэ байдлыг халахын тулд Намын тухай хууль батлагдсан байгаа.

Тэгэхээр энэ хууль хэрэгжиж эхэлсэн энэ цагаас хойш ер нь намуудын дотоод ардчиллын механизм хэр ажиллаж байх шиг байна? Намууд даргаа сонгох, гишүүддээ тайлангаа тавих, их хурлаа хийх ажлууд маань хэр явж байгаа вэ гэдгийг бас асууя.

**Н.Энхболд:** Хэнээс эхлэх вэ? Дэлгэрнараран дарга 4. Хамгийн сүүлийн асуулт их сонирхолтой асуулт байна шүү. Хэн хариулах юм бол? Дээд шүүх л хариулах байх даа.

**П.Дэлгэрнараран:** Мөнхцэцэг гишүүний асуултад хариулъя.

Нэгдүгээр асуултад бол намуудын энэ дотоод мэдээллийг цэгцэлж, нийтэд ил тод болгох, цахим хуудсанд байрлуулах ажил хэр зэрэг хэмжээтэй явж байна вэ гэж асууж байх шиг байна. Тэгэхээр бид нар бол энэ хуулийн энэ намуудын нээлттэй мэдээллийн цэсийг бол манайх цахим хуудсандаа бий болгосон. Тэр хууль хуудсан дээрээ бол

нийт энэ хуульд заасан намуудын талаарх 16 нэр төрлийн мэдээллүүдийг бид нар хуулийн хугацаанд нь байршуулсан. Одоо бол цаашидаа бас мөн энэ мэдээллийг байршуулаад тэгээд байнга энэ мэдээллээ шинэчилж явах ёстой. Намууд дээр бол орж байгаа энэ 16 төрлийн мэдээлэлд орж байгаа өөрчлөлт болгоныг цаг хугацаанд нь бүртгэж, уг мэдээллээ энэ нээлттэй мэдээлэл цэс дээрээ өөрчлөлт хийж байх ийм учиртай. Тэгэхээр энэ бол манай дээр хийгдэж байгаа ажил байгаа юм. Энэ дээр жишээлбэл, намын лого, тамганы мэдээлэл, намын даргын мэдээлэл, дүрэмтэй холбоотой мэдээлэл гэх мэтчилний ингээд ийм 16 төрлийн мэдээлэл байгаа. Уг намын талаар авах мэдээллийг байж болох бүх мэдээллүүд энэ 16 төрлийн мэдээлэл дотор орчихсон байгаа. Тэгэхээр энэ манай цахим хуудсанд одоо ингээд байршигдсан. Энэ бол байнгын шинэчлэгдэж явах ёстой мэдээлэл. гэж ингэж байна.

Хоёр дахь асуулт бол бид нар тэр намуудын санхүүжилттэй холбоотой асуудлыг хэлж байгаа. Тэгээд сая манай Сангийн яамны хүмүүс ч бас мэдээллээ манайх ч бас мэдээлж байгаа. Сангийн яам манай хоёр бол хамтарсан журам гарах учиртай. Тэгээд энэ журмаар бол бид нар энэ намын санхүүжилтийн тайлангийн бүтэц, агуулга, хөрөнгө орлого, зарлагын ангиллын тодорхойлох ийм аргачлалыг зааж өгөх ёстой. Сангийн яам бол саналаа боловсруулаад манай дээр ирүүлсэн бид нар ажиллаж байна. Ингээд үүнийг бол ойрын хугацаанд баталж мөрдүүлнэ.

Тэгэхээр энэ журам тодорхой болохоор миний түрүүний хэлээд байсан тэр нөгөө программ хөгжүүлэлтийн өгөгдлүүд бий болж, тэр программ хөгжүүлэлтээ бид нар хийх гээд байгаа олон улсын байгууллагатай хамтраад. Тэгэхээр тэр программ дээрээ бол энэ санхүүжилт, хяналт бүх зүйлүүд энэ дээр харагдаад явж байх тэгээд тэр нь бас бас байнга өөрчлөлт хийгдэж байх ийм учиртай юм байгаа юм. Тэгээд энэ

санхүүжилттэй холбоотой асуудлуудыг шийдвэрлэх хугацааны хувьд бол хууль дээр яаж заасан гэхээр энэ 7 сарын 1 буюу 2024 оны Улсын Их Хурлын сонгуулийн үр дүнгээр бий болсон нөхцөл байдлаар одоо санхүүжилтийнхээ төлөвлөлтийг хуульд заасан шаардлагын дагуу төлөвлөлтийг хийнэ гэж байгаа. Тэгэхээр энэ яг бол 25 оны улсын төсөвт бүрэн хэмжээгээр суух ёстой.

Тэгээд үүнээс өмнө бол бид нар 7 дугаар сар гэхэд 2024 оны Улсын Их Хурлын сонгуулийн үр дүн бий болсон үр дүнгээр тооцоод төсвийн хүрээний мэдэгдэлд бид нар энэ санхүүжилтийнхээ тоо хэмжээ, ангиллуудыг бол оруулаад ирэх бололцоотой гэж үзэж байгаа. Тэгээд ингээд цаашидаа хуулийн дагуу шийдэгдээд энэ ондоо батлагдахад бол бид нар 25 оны 1 сарын 1-нээс эхлээд санхүүжилтээ бүрэн хэмжээгээр тооцоод явах юм. Баярлалаа.

**Н.Энхболд:** Статистик. Аудит 5 номер.

**Я.Самбууням:** Мөнхцэцэг гишүүний асуултад хариулъя. Үндэсний Аудитын газар Самбууням.

Төрийн аудитын байгууллагаас Улс төрийн намын тухай хуулийн энэ санхүүжилт, санхүүгийн тайланг гаргахтай холбогдуулсан энэ журамд бол хуульд заасны дагуу саналаа өгч ажиллаж байгаа. Мөн энэ журам эцэслэн гарсан тохиолдолд бол энэ хариуцлага тооцох асуудал Аудитаас ямар чиг үүргийг хэрэгжүүлэх энийг хуулийг сурталчлах аудит хийх арга аргачлалаа танилцуулах энэ ажил яагаа бол хэрэгжүүлж ажиллахаар төлөвлөж байгаа. Одоогоор бол энэ дээр бол зүгээр саналаа өгөх хэлбэр дээр ажиллаж байна. Баярлалаа.

**Н.Энхболд:** 6 номер Энхбаяр дарга.

**Т.Энхбаяр:** Мөнхцэцэг гишүүний асуултад хариулъя. Жендерийн үзэл баримтлалыг тухайн харилцаа зохицуулж байгаа хууль болоод ер нь хөгжлийн бодлого төлөвлөлтөд тусгагдаагүй байдал нь бол өөрөө нөгөө тодорхой институтчилэгдсэн байдлаар бий болгоогүй гэдэг аягүй том хуулийн үр дагаврын үнэлгээ байгаа. Тэгээд үүний нэг тод жишээ нь нөгөө Улс төрийн намын тухай хуульд Жендерийн үндэсний хороо тайлан авна гэдэг заалт нь суугаагүй 13 жил болсон. Яг Жендерийн хууль дээр бид нар анх 2011 онд тайланг авна гэсэн боловч өнөө хүртэл аваагүй байгаа.

Тэгэхээр энэ хүрээнд бид нар улс төрийн нам дахь байгаа төв байгууллагуудын хүйсийн кодыг хамгийн багадаа 30-40 хувьд хүргэх асуудал дээр бол 2 сургамжийг өнөө хүртэл авсан хугацаанд үндэслэн хийхийг оролдож байна. Улс төрийн намуудтай эхний ээлжид бид нар жендерийн стратеги бодлого батлах энэ арга замыг хамгийн эхлээд манлайлалтай байгаа, парламентад суудалтай болон суудалгүй намуудад тодорхой чиглэсэн танай намын бодлого чиглэлд үзэл баримтлал, үнэт зүйлд нийцсэн жендерийн стратеги бодлогыг хуульд нийцүүлсэн болоод Улс төрийн намын тухай хуульд заасан зохицуулалтуудыг тусгасан байдлаар батлах гэдэг чиглэл.

Хоёрдугаарт нь болохоороо тухайн нам хяналтын хороо юм уу, тодорхой байгууллагуудынхаа дэргэд энэ Жендерийн дэд хороо ч юм уу жендерийн тодорхой бүтцийг бий болгож, энэ хуулийг хэрэгжүүлэхэд намын түүвшинд ажиллах ийм чиг үүрэг бүхий бүтцийг бий болгох нь зүйтэй юм гэсэн энэ хоёр чиглэлийг баримтлаад өнгөрсөн жилийн хугацаанд ажилласан.

Тэгээд өнөөдөр парламентад суудалтай Монгол ардын нам, Жендерийн дэд хороо хяналтын хорооны дэргэд байгуулсан Ардчилсан нам жендерийн бодлогоо баталсан. Хүн нам

50:50 бодлогоо зарлаад, бусад улс парламентад суудалгүй намууд бас тодорхой түвшинд энэ чиглэлд ахиц гаргаад ажиллаж байгаа. Яг хамгийн сүүлийн улс төрийн намуудтай хийсэн уулзалтаар бол Жендерийн хорооныхон хуулийн хэрэгжилт 7 сарын 1-нээс эхэлнэ, бид нар Улсын Их Хурлын сонгуулийнхаа дараа тэртээ тэргүй хүйсийн тэнцвэрт байдлын тайлангийн мэдээгээ өгөхдөө бид нар энэ нөгөө квотуудыг байгууллага тус бүр дээр хийхэд хүчин чармайлт гаргаж ажиллана. Тэгээд тухайн үедээ бас арга зүйн дэмжлэг өгч ажиллаарай гэдэг ийм саналуудыг гаргаж байгаа. Тэгээд үүнийг нь бид нар хүлээж аваад хамтран ажиллана гэсэн ийм төлөвлөгөөтэй байна.

**Н.Энхболд:** Баярлалаа. Заяадэлгэр дарга, 1 номер. Ажиллахгүй байна уу?

**С.Заяадэлгэр:** Намууд хуульд заасан бүртгэлийг хийлгэхээр Улсын дээд шүүхэд хандаж байгаа. Улс төрийн намын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд зааснаар дүрмийн өөрчлөлт буюу энэ удирдлага, дотоод зохион байгуулалтын өөрчлөлтийг 7 сарын 1-нээс хийж эхлэхээр заасан учраас энэ чиглэлийн өөрчлөлтүүд ирээгүй байна. 7 сарын 1-нээс бид хүлээн авахаар бэлтгэл хангасан байгаа.

Хууль хэрэгжиж эхэлснээс хойш бол намын даргаа бүртгүүлэх, өөрчлөх, мөн дүрмийн тодорхой нэмэлт, өөрчлөлтүүдийг бүртгүүлэх нийт 13 өргөдлийг Улсын дээд шүүхэд ишидвэрлэсэн байгаа.

Одоо намын дарга болон Сонгуулийн хуулийн 26 дугаар зүйлтэй холбоотой намын дарга тамга тэмдгийн хяналтын дугаар олгох, лавлагаа өгөх ажлыг хийгээд явж байна. Энэ хүрээнд 28 намын лавлагаа мэдээлэл олгогдсон. Намуудын ер нь энэ саяын асуулттай холбоотой, Мөнхцэцэг гишүүний асуулттай холбоотой үйл ажиллагаа

Улсын дээд шүүхэд хамааралтай эсэх нь ийм байдалтай байна.

**Н.Энхболд:** Нэг зүйл тодруулчихъя даа. Жишээ нь, сонгуульд оролцъё гээд хүсэлтээ ирүүлчихсэн байгаа намууд одоо мөрдөж байгаа дүрэм, журмынхаа дагуу намын удирдах дээд байгууллага, гүйцэтгэх дээд байгууллага энэ тэрнийхээ хурлаар орсон албан ёсоор баталгаажуулсан маягаар ирж байна уу? Ямархуу тайлантай яаж ярьдаг юм? Эс үгүй бол зүгээр л бид нар хурлаа хийсэн гээд хийсэн ч юм уу, хийгээгүй ч юм уу, хэдэн хүн орсон юм тэр юмнуудаа ойлгогдохоор, эс үгүй бол үнэмшилтэй байхаар хэмжээнд тайлбартаа ирүүлдэг юм болов уу, яадаг юм бол?

**С.Заяадэлгэр:** Тийм. Одоогийн мөрдөгдөж байгаа хууль намын хүчин төгөлдөр Улсын дээд шүүхэд бүртгүүлчихсэн байж байгаа дүрмийнхээ хүрээнд үйл ажиллагаагаа явуулаад, хурлын болон холбогдох материалуудаа ирүүлээд явж байгаа. Дээд шүүхийн зүгээс Тамгын газрын бүртгэлийн алба маань энэ бүрдүүлбэрийг, нотломжуудыг намаас ирсэн хэмжээнд шалгаж, яг хуульд заасан, журамд заасан шаардлагуудыг хангаж байна уу, үгүй юү? Хурлаа яг хийснийгээ ямар баримтуудаар нотолж ирүүлэв, Үүнийх нь үнэн, зөвийг магадлах, тэгээд бүртгэл хууль, журамд заасан шаардлагыг хангаж байвал бүртгүүлэх асуудлыг танхимд танилцуулах ийм процедураар явж байгаа.

**Н.Энхболд:** Баярлалаа. Гишүүд асуулт асууж дууслаа. Саналтай хүн байна уу?

Байхгүй байна.

Баярлалаа. Улс төрийн намын тухай хуулийн хэрэгжилтийн талаар холбогдох байгууллагуудаас мэдээлэл авлаа.



Ерөнхийдөө хуульд заасан үүргийнхээ дагуу ажлуудаа хийгээд явж байгаа юм байна. Шаардлагатай энэ хуулийн хэрэгжилтийг ийм заалтыг нь хэрэгжүүлэхэд манай байгууллага дээр ийм хүндрэл үүсэж байна гэсэн асуудлууд гарвал Төрийн байгуулалтын байнгын хороогоор дамжуулаад бас Улсын Их Хурал холбогдох газруудад мэдэгдэж тавьж байгаарай. Бид нар хамтраад ажиллана гэдгээ хэлье. Баярлалаа бүгдэд нь.

Өнөөдөр Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууслаа. Хуралдаан хаасныг мэдэгдье. Оролцсон гишүүддээ баярлалаа.

14.46 цаг

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ  
БУУЛГАЖ ХЯНАСАН:  
ШИНЖЭЭЧ Д.ОТГОНДЭЛГЭР